

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНЫ 11 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2020 оны 11 дүгээр сарын 30

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2020 оны 11 дүгээр сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Ажлын албанаас 2020 оны 11 дүгээр сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Энэ сард “Ковид-19” цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан аймгийн ИТХ-ын II Хуралдаан цахимаар 1 удаа хуралдаж 2 тогтоол, Тэргүүлэгчдийн хуралдаан цахимаар 3 удаа хуралдаж 7 тогтоол баталсан байна.

Үүнд:

Аймгийн ИТХ-ын II Хуралдаан 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр аймгийн ЗДТГ-ын Хурлын танхимд 85.3 хувийн ирцтэйгээр цахимаар хуралдлаа.

Аймгийн ИТХ-ын II Хуралдаанаар:-

1. Хөгжлийн түүчээ-Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай асуудлыг хэлэлцээд Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 2020 оны 5 сард шинэчлэгдэн батлагдаж, тус хуулинд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тавигдах шаардлага, баримт бичиг боловсруулах үе шат, цаглабарыг тодорхой болгон хуульчилж өгсөн байна.

Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь:

- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Монгол улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, үзэл баримтлал,
- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбаруудын хөгжлийн бодлого зэрэгтэй уялдуулан,
- “Аймгийн Хөгжлийн түүчээ-Төв аймаг 2024” хэтийн зорилтуудын эхний шатны хэрэгжилтийн үр дүнд үндэслэж боловсруулсан бөгөөд

дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага тогтвортой хөгжил хэмээх үзэл баримтлалд тулгуурлаж байгаа өнөө үед аймгийн хөгжлийг тогтвортойгоор хангаж авч явах зорилгоор Хөгжлийн түүчээ- Төв аймгийг хөгжүүлэх 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн хугацаанд баримтлан ажиллах чиглэлийг боловруулжээ. Үндсэн чиглэл нь:-

1. “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” бүлгийн хүрээнд:

Үндэсний үнэт зүйлсээ дээдэлсэн монгол хүнийг төлөвшүүлэх, улс үндэстнийхээ болон орон нутгийнхаа оюуны биет ба биет бус өв соёл, үнэт зүйлс, уламжлалт зан заншлыг өвлөх, хадгалах, хамгаалах, судлах, сурталчлах, түүгээр дэлгэрүүлэх, соёл урлагаар дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх, нийгэмд соёлын үнэт зүйлийг бий болгоход чиглүүлэх, Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж хэрэглэж хэвшүүлэх

2. “Хүний хөгжил” бүлгийн хүрээнд:

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог чанаржуулан, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгах, Эхийн эндэгдлийн түвшинг 100.000 амьд төрөлтөд тэглэх, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг бууруулах, улмаар дундаж наслалтыг 74.0-д хүргэх зорилт, Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагыг хүний хөгжлийн төв болгон хөгжүүлж, эрүүл аюулгүй, ээлтэй орчин, чанартай, хүртээмжтэй үйлчилгээг бий болгох,

Хүүхэд, гэр бүл, залуучуудад суурилсан нийгмийн эерэг өөрчлөлтийг бий болгож, тэдэнд ээлтэй орчинг бүрдүүлэн өв тэгш хүмүүжилтэй хүүхэд, залуучууд, гэр бүлийг төлөвшүүлэх,

3. “Амьдралын чанар ба дундаж давхарга” бүлгийн хүрээнд:

Иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллыг сайжруулан, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар өрхөд нийгмийн хөгжлийн цогц үйлчилгээг үзүүлж ядуурлын түвшинг 2020 оны түвшнээс 2.5 пунктээр бууруулж 18.0 хувьд хүргэх, ажилгүйдлийн түвшинг 0.5 пунктээр бууруулж 3.6 хувьд хүргэх,

4. “Эдийн засаг” бүлгийн хүрээнд:

Өсөлттэй өгөөжтэй эдийн засагтай аймаг болох, Нийлүүлэгч аймгаас Үйлдвэрлэгч аймаг болох гол зорилт бөгөөд тус бүлгийн хүрээнд:

- Эдийн засгийн дундаж өсөлтийг 6-12.0 хувь өсгөх;
- Дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх;
 - Эдийн засгийн бүтцийг сайжруулах,

5. “Засаглал” бүлгийн хүрээнд:

Төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг хангасан удирдлага зохион байгуулалтын тогтолцоог сайжруулан, төрийн үйлчилгээг цахимжуулж, тогтвортой, хариуцлагатай, ёс зүйтэй, чадварлаг төрийн албыг төлөвшүүлэн, гадаад харилцаа, хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх,

6. Ногоон хөгжил бүлгийн хүрээнд:

Ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлж, байгаль орчны даац чадамжид суурилж, хүний үйл ажиллагаанаас хамааралтай доройтлыг хязгаарлан зүй зохистой ашиглах нөхөн сэргээх, хамгаалах үйл ажиллагааг, нутгийн иргэд, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх. Байгаль орчны тогтвортой байдлыг хадгалан ирээдүй хойч үедээ өвлүүлж, үр өгөөжийг нь урт хугацаанд хүртэх боломжоор хангах нөхцөлийг бүрдүүлэхээр, Хүн амд амьдрах орчны зөв дадал төлөвшүүлж хүрээлэн буй орчны чанарыг сайжруулах, Экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах,

7. Амар тайван, аюулгүй нийгэм бүлгийн хүрээнд:

Амар тайван аюулгүй орчин, нийгмийг бий болгоход төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоо, хяналт, хамтын ажиллагааг өргөжүүлж, хууль сахиулах болон тусгайлан чиг үүрэгтэй байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэн, амьдрах орчны эрсдэлт нөхцөлийг бууруулах замаар урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх,

8. Бүс, орон нутгийн хөгжил бүлгийн хүрээнд:

Олон улсын нисэх онгоцны буудал байгуулагдсан давуу тал болох эдийн засгийн чөлөөт бүс байгуулах, түүнийг хууль эрх зүйн хувьд баталгаажуулах, бүсийн хөгжлийг даган бий болох их бүтээн байгуулалтын бэлтгэлийг хангаж суурь дэд бүтцийн ажлуудыг хийх, бүх сумдыг төвлөрсөн халаалттай, цэвэр бохир усны систем бүхий нийтийн аж ахуйн цогц инженерийн шугам сүлжээг хөгжүүлэх, зарим сумын төвийг улсын чанартай хатуу хучилттай автозамаар холбох, сум, орон нутгийн нийгмийн болон төрийн үйлчилгээний барилга байгууламжийг барих, засварлах ажлуудыг хийж иргэдийг нутаг орондоо ая тухтай, амьдрах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах зэргээр “Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн бүтцийн дагуу 8 бүлэг, 8 зорилгын хүрээнд 37 зорилт, 178 үйл ажиллагаа, 163 шалгуур үзүүлэлттэй батлав.

2. Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж аймгийн таван жилийн үндсэн чиглэлийн зорилтуудыг “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, аймгийн хөгжлийн жил жилийн төлөвлөгөө, төсөв, тухайн салбарын хөгжлийг тодорхойлсон төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлэх, “Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, аймгийн хөгжлийн төлөвлөлтийн бусад баримт бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг угтаж хийх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах, Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгуулах, гадаад, дотоод хөрөнгө оруулагчид, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоо дэмжлэгийг авах, төрөл бүрийн төсөл, хөтөлбөр, зээл тусламжид хамруулах замаар бүрдүүлж ажиллах, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, аймгийн хөгжлийн жил жилийн төлөвлөгөө, тухайлсан төлөвлөлтийн баримт бичгийн биелэлтийг тооцохдоо аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилтуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гарган шаардлагатай арга хэмжээ авч байхыг дараах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргад даалгалаа.

“Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д Хурлын Хороодын дүгнэлт, Төлөөлөгчдийн саналыг тусган батлуулж, Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж, дүгнэн, тайланг хоёр жил тутам Хурлын хуралдаанаар хэлэлцүүлж байхыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгов.

“Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн зорилтуудыг өөрийн сумын хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусган батлуулж, хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөлөө.

2. Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн ойн сангаас 2021 онд бэлтгэх модны хуваарь батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн хэмжээнд 2021 онд ойн сангаас бэлтгэх модны хэмжээ, хуваарийг батлан байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын

85 хувийг ойн хөнөөлт шавж, өвчний хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, суурин судалгаа хийх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, унтраах, ойн үр бэлтгэх ой сонгох, тарьц, суулгац ургуулах, ойг нөхөн сэргээх, тарьж ургуулах, байгалийн сэргэн ургалтад туслах, ойн зурвас, модлог ургамлын цэцэрлэг байгуулах, голын эх, эрэг дагуу мод тарьж төгөл байгуулах, хууль бус мод бэлтгэх зөрчлийг бууруулах, хяналт шалгалт хийх зэрэг арга хэмжээнд зохих журмын дагуу төлөвлөн, зарцуулж байгаад тавих хяналтыг өндөржүүлж ажиллах, Ойгоос мод бэлтгэх ажлыг холбогдох заавар, журмын дагуу гүйцэтгүүлж, үйлдвэрлэлийн, арчилгааны болон цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэсэн 100 шоо метр мод тутамд 2,0 га талбайд ойжуулалтын ажлыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр хийлгэх ажлыг зохион байгуулах, өмнөх онуудад улс, орон нутгийн төсвийн болон өөрийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг гүйцэтгээгүй, дутуу хийсэн аж ахуйн нэгж, байгууллагад ойгоос мод бэлтгэх зөвшөөрөл олгохгүй байхыг аймгийн Засаг даргад даалгав.

Тус тогтоол батлагдсантай холбогдуулан сумын төсөвтөө, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтын дагуу ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувийг, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасан ойн аж ахуйн арга хэмжээнд зарцуулахаар тусган батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ойн сан бүхий сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөв.

- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн II Хуралдаанаар:

2020-2024 оны аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн II хуралдаан 11-р сарын 18-ны өдөр хуралдаж 9 асуудал хэлэлцэж 6 тогтоол батлан, 1 асуудлыг Тэргүүлэгчдийн дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр буцаан Хурлын хороодод 1 асуудлыг дүгнэлт гаргуулахаар шилжүүлэв.

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны зохион байгуулалтыг хангах зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албанаас шинэчлэн боловсруулсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдааны дэгийн төслийг хэлэлцээд “Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дэгийг шинэчлэн батлах тухай” тогтоолыг батлан Хуралдааны зохион байгуулалт, дэг журмыг хуралдааны дэгийн хүрээнд чанд сахин ажиллахыг Тэргүүлэгчдэд үүрэг болгон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны дэгийн жишгээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдааны дэгийг боловсронгуй болгон мөрдөж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд зөвлөв.

2. Аймгийн Сонгуулийн хороог татан буулгах тухай асуудлыг хэлэлцээд аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулж явуулсан аймгийн сонгуулийн хороог 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн татан буулгахаар шийдвэрлэв.

3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн “Хуралдааны тов тогтоож, хэлэлцэх асуудал батлах тухай” 01-р тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд тус тогтоолын 1 дүгээр заалтын “2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 09 цагт.....” гэснийг “2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 09 цагт цахим хэлбэрээр...” гэж өөрчилж 2 дугаар заалтад “2.3. Ойн сангаас 2021 онд бэлтгэх модны хуваарь батлах тухай” гэж тус нэмж өөрчлөв.

4. Хуралдааны тов тогтоож, хэлэлцэх асуудал батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Гуравдугаар хуралдааныг 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 09 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын Хуралдааны танхимд хуралдуулахаа тогтоож Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл, аймаг хөгжүүлэх 2021 оны төлөвлөгөөний төсөл, аймгийн 2021 оны төсвийн төсөл, иргэнд 2021 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлыг тогтоох тухай асуудлуудыг хэлэлцэхээр шийдвэрлэв.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төслүүдээр нийтийн сонсох ажиллагааг зохион байгуулж, нөлөөллийн шинжилгээ хийн нягтлан боловсруулж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн, “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дүрэм”-ийн 18 дугаар зүйлд заасан шаардлага хангасан материалыг 11 дүгээр сарын 27-ны өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхийг аймгийн Засаг даргад даалгав.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гуравдугаар хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засаг даргын өргөн мэдүүлсэн асуудлуудыг Хурлын Хороодоор судлуулан хянуулж, боловсруулалтын түвшинг нь сайжруулж, дүгнэлт гаргуулан Тэргүүлэгчдийн Хуралдаанаар урьдчилан хэлэлцүүлж, Хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргад үүрэг болголоо.

5.Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар 2020 оны 10, 11, 12 дугаар сард хэлэлцэх асуудлуудын жагсаалтыг батлав.

6.Хөгжлийн түүчээ-Төв аймгийг хөгжүүлэх 5 жилийн Үндсэн чиглэлийн төслийн анхны хэлэлцүүлэгийг хэлэлцээд Хурлын Эдийн засаг, төсөв санхүү өмчийн бодлогын хороо, Үйлдвэрлэл дэд бүтцийн хороо, Нийгмийн бодлогын хороо, Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороо, Хүний эрхийн хороо, Нутгийн удирдлага хууль хяналт, гадаад харилцааны хороодод дүгнэлт гаргуулахаар шилжүүлэв.

7.Аймгийн Засаг даргын орлогчийг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцээд Тэргүүлэгчдийн дараагийн Хуралдаанаар хэлэлцүүлэхээр буцаав.

8.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны бүтэц орон тоонд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны орон тоог ИТХ-ын дарга, Нарийн бичгийн дарга, Ажлын албаны ахлах мэргэжилтэн-1, мэргэжилтэн-8, жолооч-2, нийт 13 орон тоогоор шинэчлэн тогтоов.

Аймгийн ИТХ-ын зарим Тэргүүлэгчдийн санал болгосны дагуу аймгийн Онцгой Комиссын мэдээлэл болон цаг үеийн нөхцөл байдлын тухай мэдээллийг сонсов.

Аймгийн ИТХ-ын 01 дүгээр хуралдаанаар 8 асуудал хэлэлцэж 6 тогтоол батлав.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит бус-1 дүгээр Хуралдаанаар:-

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит бус-1 дүгээр хуралдаан 11-р сарын 23-ны өдөр хуралдаж 4 асуудал хэлэлцэв.

1.Аймгийн ИТХ-ын дүрэмд нэмэлт оруулах тухай ажлын хэсгийн мэдээллийг хэлэлцээд тус асуудлын боловсруулалтын түвшинг сайжруулж дахин танилцуулахаар буцаав.

2.Хөгжлийн түүчээ-Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөлд Хурлын Эдийн засаг, төсөв санхүү өмчийн бодлогын хороо, Үйлдвэрлэл дэд бүтцийн хороо, Нийгмийн бодлогын хороо, Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороо, Хүний эрхийн хороо, Нутгийн удирдлага хууль хяналт, гадаад харилцааны хороодоос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Хурлын хуралдаанд шилжүүлэв.

3.Ойн сангаас 2021 онд бэлтгэх модны хуваарь батлах тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

4.Ойн сангаас 2021 онд бэлтгэх модны хуваарь батлах тухай асуудалд Хурлын Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Хурлын Хуралдаанд шилжүүлэв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит бус 1-дүгээр хуралдаанаар 2 асуудлыг Хурлын Хуралдаанд шилжүүлж, 1 асуудлыг боловсруулалтын түвшинг сайжруулахаар хойшуулав.

Аймгийн ИТХ-ын III Хуралдаан 2020 оны 12-р сарын 03-ны өдөр Хуралдахаар тов тогтсонтой холбогдуулан аймгийн Засаг даргаас Хуралдааны асуудлуудыг 11-р сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн бөгөөд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн III Хуралдаан 2020 оны 11-р сарын 30-ны өдөр хуралдлаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн III Хуралдаанаар:-

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн анхны хэлэлцүүлэг хэлэлцүүлж Хурлын Эдийн засаг, төсөв санхүү өмчийн бодлогын хороо, Үйлдвэрлэл дэд бүтцийн хороо, Нийгмийн бодлогын хороо, Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороо, Хүний эрхийн хороо, Нутгийн удирдлага хууль хяналт, гадаад харилцааны хороодод дүгнэлт гаргуулахаар шилжүүлэв.

2. Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцүүлж Хурлын Эдийн засаг, төсөв санхүү өмчийн бодлогын хороо, Үйлдвэрлэл дэд бүтцийн хороо, Нийгмийн бодлогын хороо, Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороо, Хүний эрхийн хороо, Нутгийн удирдлага хууль хяналт, гадаад харилцааны хороодод дүгнэлт гаргуулахаар шилжүүлэв.

3.Аймгийн 2021 оны төсвийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцээд Хурлын Эдийн засаг, төсөв санхүү өмчийн бодлогын хороонд дүгнэлт грагуулахаар шилжүүлэв.

4.Иргэнд 2021 онд өмчлүүлэх газрын хэмжээ байршил тогтоох тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

5.Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн хөрөнгө шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцээд акталж устгах барилга, дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгсэл, балансаас балансад шилжүүлэх хөрөнгө, акталж устгах тоног төхөөрөмж, тавилга эд хогшилг тогтоолын хавсралтаар тус тус батлав.

Хөрөнгө шийдвэрлэх тухай тус тогтоолын дагуу дуудлага худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, төлбөрийг аймгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган Төрийн болон орон нутгийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд бүртгэж, акталж устгах тоног төхөөрөмж, тавилга эд хогшилыг байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулахыг аймгийн Засаг даргад даалгав.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн III Хуралдаанаар 5 асуудал хэлэлцэж 4 асуудлыг Хурлын Хуралдаанд шилжүүлж 1 тогтоол батлав.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас батлагдан гарсан тогтоол, шийдвэрүүд цаг хугацааны мэдээ, мэдээлэлийг khural.mn сайт болон Төв аймгийн ИТХ facebook page хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллаж байна.

Энэ сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 21 албан бичиг ирснийг бүртгэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга болон нарийн бичгийн даргад танилцуулан хариу өгөх шаардлагатай 4 албан бичигт хариуг өгч ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 7 өргөдөл ирснийг бүртгэн авч 6 өргөдлийн хариуг хуулийн хугацаанд багтаан шийдвэрлэж хариуг өгч ажилласан байна. 1 өргөдлийн хугацаа болоогүй шийдвэрлэх шатандаа байна.

Аймгийн ИТХ-ын дарга, Хурлын Ажлын албанаас салбарын яамд болон аймгийн Засаг дарга, хэлтэс агентлагт болон холбогдох албан байгууллагад 39 бичиг гарган хүргүүлж ажиллалаа.

Улсын Онцгой комисс, Засгийн газрын хуралдааны 178 дугаар тогтоолоор 11 дүгээр сарын 12-ны 06:00 цагаас эхлэн тав хоног Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан аймгийн Онцгой комиссын шуурхай хуралдаан зарлаж бүх нийтийн бэлэн байдлын үед Төв аймгийн хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэний дагуу төрийн бүх байгууллагууд тус зэрэгт шилжиж ажиллалаа.

2020 оны 11-р сарын 12-ний өдөр аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн Ковид цар тахлын нөхцөл байдлын улмаас бэлэн байдлын зэрэг шилжсэн үеийн нөхцөл байдал өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүн худалдаалдаг бөөний төвүүд болон дэлгүүрүүдийн үйл ажиллагаатай танилцаж, худалдаа эрхлэгч болон иргэдтэй уулзсанаас гадна аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, онцгой комиссын гишүүд нэгдсэн эмнэлэгийн үйл ажиллагаа, халдварын үед хэрхэн ажиллах бэлэн байдалтай танилцаж ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн үйл ажиллагааны тухай" тогтоолын дагуу авах хариу арга хэмжээний тухай аймгийн Онцгой Комиссоос өгсөн үүрэг чиглэл, Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах, Төрийн албаны стандартыг хэрхэн хангах, сайжруулах талаар холбогдох үүрэг чиглэлийг 27 сумдын удирдлагуудад өглөө.

Улсын хэмжээнд бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосон байгаа энэ цаг үед тусламж, дэмжлэг хэрэгтэй байгаа айл өрхөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд хандив өгч, хандивын аяны хүрээ тэлсээр байгаа бөгөөд аймгийн ИТХ-ын төлөөлөгч Г.Сурмаа аймгийн Онцгой комиссоор дамжуулан Зуунмод сумын Нацагдорж (5 дугаар) багийн 315 өрхөд 5 сая төгрөгийн үнэ бүхий хүнсний голлох бүтээгдэхүүний багц, амны хаалтын хамт хандивласан бөгөөд хүйтний улиралд хэрэглэх түлээ, нүүрсийг үе шаттайгаар өгөхөөр шийдвэрлэж эхний ээлжинд 60 өрхөд хандивлалаа. Түүнчлэн "Унагалдайн Андууд"цэцэрлэгийн удирдлага, эцэг эхчүүдийн хүсэлтийн дагуу цэцэрлэгийн насны 10 хүүхдэд дулаан куртик, гутал, хувцас зэргийг өгсөн байна.

Монгол Улсын Засгийн газар, УОК-оос бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорионы дэглэм тогтоосон цар тахлын хүнд, хэцүү нөхцөлд иргэдэд туслах хандив, тусламжийн аянд аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг нэгдэхийг уриалж ажиллалаа.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн ээлжит сонгуулийн үр дүнгээр бий болсон сумын Хурал анхдугаар хуралдаанаараа сумын Засаг даргад Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу нэр дэвшүүлэн дээд шатны Засаг даргад уламжилж, нэр дэвшигчдийн хуулийн шаардлага хангасан эсэхийг судлан үзэж, холбогдох хууль хяналтын байгууллага дүгнэлт гаргасаны дагуу сумын Засаг дарга нарыг томилох, бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж буй Засаг дарга нарын ажлыг хүлээлцэх цахим хуралдааныг 2020.11.27, 2020.12.02-ны өдрүүдэд зохион байгуулж аймгийн Засаг даргын захирамжаар 25 сумын Засаг даргыг томилоод байна.

Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төв 1111 төвөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 58 өргөдөл гомдол хуваарилагдан ирсний 49 нь шийдвэрлэгдэн 9 шийдвэрлэх шатандаа байна.

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхайг 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж 9 үүрэг даалгавар өгч хэрэгжих шатандаа байна. Уг нэгдсэн шуурхайг цахимаар зохион байгуулж цар тахалын үеийн хүний бөөгнөрөл үүсгэхгүй, эрсдэл үүсгэхгүй байхаар зохион байгууллаа.

ЗГХЭГ-аас хүссэн орон нутгаас Улаанбаатар хотод хөл хорионд орсон төрийн албан хаагчдыг судалгааг гарган цахимаар 30 төрийн албан хаагчийг хугацаанд нь хүргүүлэв.

Мобиком корпорациас цар тахлын үед онцгой үүрэг гүйцэтгэж буй мобикомын хэрэглэгч төрийн албан хаагчдын судалгааг гарган өгч нийт 424 төрийн албан хаагчид 3,0 сая төгрөгийн үнэ бүхий дата, нэгжний урамшуулалд хамрууллаа.

Аймгийн Засаг даргын зөвлөл 11 дүгээр сарын 11, 25-ний өдрүүдэд хуралдаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээс гадна дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. “Төв аймгийг хөгжүүлэх 5 жилийн Үндсэн чиглэл”-ийг батлах асуудлыг хэлэлцэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэлээ.
2. Ойн сангаас 2021 онд бэлтгэх модны хуваарь батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэлээ.
3. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлтэй танилцаад аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэлээ.
4. Аймаг хөгжүүлэх 2021 оны төлөвлөгөөний төсөлтэй танилцаад аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэлээ.
5. Аймгийн 2021 оны төсвийн төсөлтэй танилцаад аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэлээ.
6. Иргэнд 2021 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлыг тогтоох тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэлээ.
7. Хөрөнгө шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэлээ.
8. Оны эхнээс аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр-135, Засаг даргын “Хүндэт жуух бичиг”-ээр 92 иргэнийг шагнаад байна.

Төрийн албаны стандартын хүрээнд: 1. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд: 2020 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар Салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 25 тогтоол гаргасан бөгөөд үүнээс 100% биелсэн 19, 70%-ийн гүйцэтгэлтэй 5, 30%-ийн гүйцэтгэлтэй 1 шийдвэр байна. Тогтоолын биелэлтийн дундаж 91.2% буюу 4.56 оноотой байна. Тогтоолын төрлөөр авч үзвэл:

№	Тогтоолын агуулга	Тоо
1	Журам, дэг батлах	2
2	Төлөвлөгөө батлах, ажил зохион байгуулах.	4
3	Шалгалтын комисс, дэд ажлын хэсэг байгуулах	10
4	Нэр дэвшүүлэх	7

5	Шагналд уламжлах, зэрэг дэв олгуулах	2
НИЙТ ДҮН		25

Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн чиглэлийн дагуу Төв аймгийн хэмжээнд 2019.01.-2020.10 сар хүртлэх шинэлэг ажлын жагсаалт гарган хүргүүлэв.

Иргэд, олон нийтэд Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагааг сурталчилж, ерөнхий болон тусгай шалгалтын талаар мэдээлэл хийж, төрийн албан хаагчдад зөвлөгөө өгөх зорилгоор ТАЗСЗ, аймгийн ЗДТГ-ын ТЗУХ, түүний харьяа агентлагуудтай хамтран 2020.10.30-ны өдөр "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр дараах үйлчилгээг үзүүлээ.

1. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны танилцуулга, гишүүдийн танилцуулга
2. Ерөнхий болон тусгай шалгалтын талаар мэдээлэл /Видео шторк, асуулт хариулт/
3. ТАХ-ийн нийгмийн асуудалтай холбоотой ганцаарчилсан болон хэсэгчилсэн зөвлөгөө
4. Төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан “Онч үг” /Афоризм/ зохиох уралдааны шагнал гардуулах. /50 албан хаагчийн 60 гаруй материал ирсэн/
5. Төрийн албаны сорилын агуулга бүхий "АХА" тэмцээн зохион байгуулах. /20 иргэн оролцсон/
6. Төрийн албаны шалгалтын сорилын ном худалдаа /40 ном худалдаалсан/

27 сумын удирдлага, төрийн албан хаагчидтай хийсэн 2 удаагийн өргөтгөсөн цахим хурлаар ТА3-ийн 2020 оны 01, 03, 04 дүгээр зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар 3-7 зүйлийн чиглэл өгч ажиллаа.

Аймгийн 5 жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 жилийн ажлын төлөвлөгөөнд ТАЗСЗ-өөс хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, ажил үйлчилгээний санал өглөө.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу **242 иргэн нөөцийн бүртгэл, мэдээллийг шинэчиллээ.**

№	Нөөцийн бүрэлдэхүүн	Нөөцөд байгаа иргэний тоо
1	Ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэний нөөц /2018-2020/	242
2	Төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц	7
3	Төрийн албаны тухай хуулийн 62.1.4-т заасан болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоолгож /дээдофицер, офицер, ахлагч/ төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэний нөөц	2
4	Эрх бүхий байгууллагын шийдвэрээр нөхөр /эхнэр/ нь өөр орон нутаг, гадаад улс, олон улсын байгууллагад шилжин ажиллах болсон, эсхүл гэр бүлийн хүнд өвчтэй аль нэг гишүүнээ асрах зайлшгүй шаардлагын улмаас төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц	1
5	Төрийн албан тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжихээс өмнө нөөцөд байхаар заалтаар ажлаас чөлөөлөгдсөн	2
НИЙТ ДҮН		94

2020 оны 11 дүгээр сард зохион байгуулсан төрийн албаны Ерөнхий шалгалтад тэнцсэн 160 иргэний боловсрол, мэргэжил, холбоо барих утасны жагсаалт бүхий лавлагаа 27 сумын ЗДТГ-ын дарга, 2 агентлагийн даргад цахимаар хүргүүлсэн.

ТАЗСЗ-ийн үйл ажиллагаанд иргэдээс үнэлгээ дүгнэлт авах зорилгоос цахим санал асуулгыг 2020.11.20-оос эхлэн явуулж байна.

ТЗАХ-ийн тангараг өргөх болзол хангасан 16 хүнийг тангараг өргүүлэх шийдвэрийг ТАЗСЗ-ийн 2020.11.17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталгаажуулсан. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг цуцлагдсаны дараа ёслолын журмыг баримтлан тангарагийг тухайн байгууллагадаа өргүүлэх чиглэл өгсөн.

Босоо удирдлагатай 7 байгууллагад орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдыг сумдын онцгой комиссын үйл ажиллагаанд ажлын хуваарийн дагуу оролцуулах үүрэг чиглэл өгсөн.

Төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаал, Төрийн байгууллагын төсвийн шууд захирагчийн 195 сул орон тооны судалгааг 2020.11.25-ны байдлаар гаргалаа.

Аймгийн ГБХЗХГ-аас санаачлан хэрэгжүүлж буй “Хайраар дүүрэн богц” эмзэг бүлгийн өрхөд дэмжлэг үзүүлэх аянд ТАЗСЗ-өөс 200.000 төгрөгийн хандив өглөө.

2020 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй	Шийдвэрлэлтийн хувь
1	Албан бичиг	142	107	97	10	90.65%
2	Өргөдөл, гомдол	7		7	0	100%

Хүлээгдэж буй 10 албан бичиг нь туслах түшмэлийн албан тушаалын сонгон шарлгаруулалтын захиалга байна.

Тайлант хугацаанд салбар зөвлөлөөс 102 албан бичиг гадагш явуулснаас хариутай 43 бичиг байна. Үүнээс 37 хугацаандаа шийдвэрлэгдэж 6 хугацаа болоогүй хүлээгдэж байна.

2. Сургалт, мэдээллийн чиглэлээр:

ТАЗ, Мерит төсөлтэй хамтран зохион байгуулсан “ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН СУУРЬ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ” цахим семинарт оролцсон.

Аймгийн ЗДТГ-ын дарга бөгөөд СЗ-ийн дарга эрхэлсэн түшмэлийн багц сургалт, СЗ-ийн НБД ахлах түшмэлийн багц сургалтад тус тус хамрагдаж байна.

3. Сонгон шалгаруулалтын чиглэлээр:

Төрийн албаны Ерөнхий шалгалтыг 2020.11.06-08-ны өдрүүдэд Төв аймагт зохион байгуулж, бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлтийг 98.9%-тай хэрэгжүүллээ. Шалгалтын үр дүнг танилцуулбал:

	Огноо	Цаг	Ирвэл зохих	Ирсэн	Ирээгүй	Ерөнхий мэдлэгийн шалгалт	Монгол хэл бичгийн шалгалт	Дүн шинжилгээ хийх чадварын шалгалт	Нийт хувь
1	2020.11.06	8:00	31	26	5	8	6	5	19.2
2		10:30	31	24	7	9	8	8	33.3
3		13:00	31	29	2	9	8	8	27.6
4		15:30	31	29	2	15	13	13	44.8
5		18:00	31	28	3	16	16	16	57.1
6	2020.11.07	8:00	31	24	7	11	10	10	41.7
7		10:30	31	16	15	8	5	5	31.3
8		13:00	31	19	12	9	8	8	42.1
9		15:30	31	24	7	15	14	14	58.3
10		18:00	31	24	7	13	13	13	54.2
11	2020.11.08	8:00	31	23	8	13	13	13	56.5
12		10:30	31	23	8	17	14	14	60.9
13		13:00	31	21	10	13	13	13	61.9
14		15:30	31	23	8	8	8	8	34.8
15		18:00	31	21	10	12	12	12	57.1
	НИЙТ ТОО		465	354	111	176	161	160	45.2%

	ХУВЬ		100%	76.12%	23.87%	49.72%	45.48%	45.2%	
--	------	--	------	--------	--------	--------	--------	-------	--

Шалгалтад тэнцсэн иргэдийг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 371 дүгээр тогтоолоор төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэсэн.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв:

2020 оны 11 дүгээр сард Төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт 20 байгууллага 300-аад төрлийн үйлчилгээг **3975** иргэнд, өдөрт дунджаар 100-200 иргэнд хүргэж байна. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ, арга хэмжээний мэдээллийг “Өлзий”, TBS, Төв, Сүлд, Live телевизүүдтэй, контент хуваах хэлбэрээр ТВ5, ТВ9 телевизүүдтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Мөн Аймгийн албан ёсны веб сайт, пейж хуудас, мэдээллийн болон урсдаг самбар зэрэг эх сурвалжаар иргэд, олон нийтэд түгээж байгаа 11 дүгээр сард аймгийн веб сайтад **32**, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пейж хуудсанд **57** мэдээ мэдээлэл тус тус нийтлэгдлээ. Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **3-н** дугаарыг бэлтгэн иргэд олон нийтэд хүргэсэн. Мөн бусад 7 төрлийн телевизүүдийн мэдээний цагаар **45** мэдээ мэдээлэл цацагдсан байна. Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **3** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Одоогийн байдлаар хугацаа болоогүй **2** гомдол байна.

Мөн тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны E-mongolia цахим системийг нэвтрүүлж 9 байгууллагын 54 төрлийн лавлагаа мэдээллээр иргэдэд үйлчилж байгаа бөгөөд 11 сард аймгийн хэмжээнд **1389** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ТҮНТөвийн операторуудаас **159** лавлагаа үйлчилгээ авчээ.

Мэргэжлийн хяналтын чиглэлээр:

Тус газар нь 2021 онд 20 хяналтын чиглэлээр 390 объектод 599 төлөвлөгөөт шалгалт, 140 объектод 177 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөлөө.

Бүх нийтийг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан газрын даргын 2020.11.12-ны өдрийн А/48 дугаар тушаалаар Байнгын ажиллагаатай шуурхай штабын бүтэц, бүрэлдэхүүнийг 5 баг, 30 хүний бүрэлдэхүүнтэй томилж, гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө батлан чиг үүргийг тодотголоо.

Шинэ коронавирус/ 2019-nCoV/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангаж ажиллах улсын байцаагч, ажилтан, орлон ажиллах болон шаардлагатай үед нэмэлтээр ажиллах улсын байцаагч, ажилтны нэрсийг гарган Мэргэжлийн хяналтын газрын даргын “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарь батлах тухай” А/10 тоот тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тушаалын хэрэгжилтийн хүрээнд 24 цагаар хариуцлагатай жижүүрийн үүргийг бүх албан хаагчид ээлжлэн гүйцэтгэж, мэдээ мэдээллийг холбогдох газарт шуурхай хүргэн хяналт тавин ажиллаж байна

УОК-ын 2020 оны 12 дугаар тогтоолын дагуу Аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн А/561 дугаар захирамжаар үзвэр үйлчилгээ, олон нийтийг хамарсан хурал цуглаан, сургалт, спортын тэмцээн уралдаан, соёл урлаг, кино театр, цахим болон бага насны хүүхдийн төрөл бүрийн тогтлоомын газар,баар, саун, түр сургалтын байгууллага,үсчин, гоо сайхан, халуун, ус зочид буудал,, зурагчин, алт мөнгөний дархан, барилгын материалын дэлгүү, зурагчин, хими цэвэрлэгээ зэрэг газруудын үйл ажиллагааг түр зогсоосон шийдвэрийн хэрэгжилтэд Аймгийн Онцгой байдлын газар, цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнтэй хамтран нийт 64 газарт хяналт тавьж сэрэмжлүүлэг, зөвлөмж нийт 292 ширхэгийг хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/562 дугаар захирамжаар аймгийн нутаг дэвсгэр дэх хайпермаркет, супермаркет, минимаркет, хүнсний дэлгүүр, бөөний төв, агуулах худалдаа болон олон улс, улсын чанартай авто зам дагуухаас бусад төв суурин газар үйл ажиллагаа явуулж байгаа ресторан, кафе, нийтийн үйлчилгээтэй цайны газар, сүлжээ хоолны газар, хүргэлтийн хоолны газруудын үйлчлэх цагийг хуваарийг 9-19 цаг болгосон. Энэ захирамжийн хэрэгжилтэд Аймгийн Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнтэй хамтран Зуунмод сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 118 объектод хяналт тавьж 194 ширхэг зөвлөмж тарааж, мэргэжлийн зөвлөгөө өгсөн. Мөн Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч иргэн, ААН-үүдэд МХГ-ын 2020 оны 466 дугаар албан бичгээр мэдэгдэл хүргүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих тухай 01/252 дугаартай удирдамж, Аймгийн мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/153 дугаартай удирдамж, Төв аймгийн Онцгой комиссын хуралдаанаас өгсөн үүргийн дагуу Зуунмод сумын 1-6 багт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, гудамж, талбай, орон сууцны орц зэрэг нийт 319 объектын 259043.7 квм талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийг Төв Чандмань ДЭХГ,ОБГ, Мал эмнэлэгтэй хамтран хийлгэж, халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын газрын 18 байцаагч хяналт тавьж ажиллаж байна.

-МХЕГ-ын даргын баталсан 2020 оны 01/248 дугаартай “Хүнсний үйлдвэр, хадгалалт, түгээлтийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх” тухай удирдамжийн дагуу Бүтээгдэхүүний хадгалалтын горим зөрчсөн, хугацаа дууссан, гарал үүсэл нь тодорхойгүй 83 нэр төрлийн 207 ширхэг, 7.95 кг, 589570 /Таван зуун наян ес мянга таван зуун дал/ төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хураан устгаж, 43 нэр төрлийн 85 ширхэг 12.43 кг 541625 / Таван зуун дөчин нэгэн мянга зургаан зуун хорин тав/ төгрөгийн түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүнийг буцааж, татан авалт хийлгүүлэн, 15 заалттай улсын байцаагчийн 1 албан шаардлага, бүтээгдэхүүн устгах 1 акт үйлдэж ажилласан.

Итгэмжлэгдсэн лаборатори нь өнгөрсөн 1 сарын хугацаанд COVID 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 32 сорьцыг шалгаж хүлээн авч 115 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулан хугацаа хэтрүүлэхгүй олгосон байна. Үүнээс үрийн улаан буудай, арчдас, бохир усны 11 сорьц 19 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй гарсан.

Онцгой байдлын газрын хүрээнд:

№	Төрөл	Мэдээний агуулга	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ
1.	Объектын гал түймэр /зөрчил/	Төв аймгийн Зуунмод сумын Нацагдорж багийн 3-р гудамжны 13 тоотод иргэн н.Зоригтбаатарын хашаанд хураалттай байсан өвс шатаж байна гэсэн дуудлагыг 2020.11.11-ний өдрийн 17:00 цагт хүлээн авсан.	Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр ангийн 6 алба хаагч, 1 автомашинтай ангийн байрлалаас гарч 17:12 цагт унтраасан.
2.	Объектын гал түймэр	Төв аймгийн Мөнгөнморьт сумын Байдлаг 2-р багийн “Ярдаг” гэдэг газарт /сумын төвөөс баруун хойд зүгт 30 км-т/ малчин Э.Энх-Оюуны өвөлжөөний 40*40 харьцаатай хашаа шатаж байна гэсэн дуудлагыг 2020.11.12-ний өдрийн 16:29 цагт хүлээн авсан.	Гал түймэр унтраах, аврах 75 дугаар ангийн захирагч ахлах дэслэгч З.Билгүүнээр ахлуулсан 6 алба хаагч, тус сумын 4 иргэн 1 автомашинтай ангийн байрлалаас 16:31 цагт гарч хаягын дагуу хүрэлцэн очиход иргэн Э.Энх-Оюун хог шатааж байгаад гал алдаж өвөлжөөний хашаа нь шатсан иргэд өөрсдөө унтраасан. Уг дуудлага нь зөрчлийн дуудлага байсан.
3.	Объектын гал түймэр /зөрчил/	Төв аймгийн Зуунмод сумын Зүүндэлгэр баг А-19-р гудамжны 7 тоотод айлын гэр шатаж гэсэн дуудлагыг 2020.11.12-ний өдрийн 12:39 цагт хүлээн авсан.	Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр ангийн 6 алба хаагч, 1 автомашинтай ангийн байрлалаас гарч ажиллаж унтраасан.
4.	Объектын гал түймэр	Төв аймгийн Сүмбэр сумын Сүмбэр багийн "Өнөр хороолол" гэдэг газар /сумын төв/ 10-р	Сумын Тамгын газрын 7 алба хаагч, 10 иргэн 2 автомашинтай

		гудамжны 13 тоотод оршин суугч иргэн Б.Давгажамцын хашаанд 500 боодол 10 тонн өвс шатаж байна гэсэн дуудлагыг 2020.11.13-ны 16:13 цагт хүлээн авсан.	ажиллаж байна гэж мэдэгдсэн. Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 40 дүгээр ангийн 8 алба хаагч, 2 автомашинтай ангийн байрлалаас гарсан. 20 км замыг туулан 16:30 цагт очиж, галын тархалтыг зогсоосон. Уг гал түймэрт өртсөн хүн байхгүй.
5.	Хээрийн түймэр /мэдээлэл/	Төв аймгийн Баянжаргалан сумын Улаан-Ухаа багийн "Уран бор" гэдэг газарт /сумын төвөөс зүүн урд зүгт 40 км-т/ хээрийн иүймэр гарсан гэсэн мэдээллийг 2020.11.16-ны өдөрийн 13:06 цагт хүлээн авсан.	Сумын ИТХурлын дарга Г.Золбаатараар ахлуулсан 12 хүн, 2 автомашинтай ажиллаж 13:06 цагт бүрэн унтраасан. нийт 3 га талбай өртсөн.
6.	Объектын гал түймэр	Төв аймгийн Эрдэнэ сумын Баянтуул багийн "Баруун баянгийн их" Гялалзахийн хүн толгой гэдэг газарт /сумын төвөөс хойд зүгт 110 км-т/ /Төв аймгийн төвөөс зүүн хойд зүгт 193 км-т/ малчин Б.Пүрэвцэрэн гэдэг айлын 7x4 харьцаатай дүнзэн байшин, 5x4 харьцаатай таамбар 2020.11.28-аас 2020.11.29-ний шилжих шөнө 01:30 цагт бүрэн шатсан тухай мэдээг 2020.11.29-ний 21:23 цагт хүлээн авсан.	Сумын хэсгийн төлөөлөгч ахлах дэслэгч Д.Цэрэнпил, БОУХБайцаагч Ш.Гэрэлт-Од нар 18:01 цагт очиж үзлэг хийсэн. Уг гал түймэрт гэмтэж бэртсэн хүн байхгүй.
7	Аврах ажиллагаа	Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт Улаанбаатар хотоос Өмнөговь аймгийн Мандал-овоо сум руу явж байсан портер загварын автомашин хүнсний бүтээгдэхүүн ачсан автомашин мотор цохисон байдалтай аймгийн төвөөс урд зүгт 6 км-т зогссон байна гэсэн дуудлагыг 2020.11.22-ны өдрийн 00:05 цагт хүлээн авсан.	Аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх аврах салбарын дарга а/д З.Отгонзулаар ахлуулсан 3 алба хаагч, 1 автомашинтай ажиллаж 02:00 цагт ангийн байрлалд ирсэн
8	Аврах ажиллагаа	Төв аймгийн Лүн сумд Улаанбаатар хотоос Увс аймгийн чиглэлд зорчиж явсан 12 эмчийн автомашин эвдэрсэн тухай дуудлагыг 2020.11.27-ны өдрийн 00:40 цагт хүлээн авсан.	Сумын эрэн хайх аврах бүлгийн дарга д/ч Б.Мөнхбаяраар ахлуулсан 3 алба хаагч, 1 автомашинтай ажиллаж сумын эмнэлэгт хүргэж өгсөн.

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

Хууль зүй, дотоод хэргийн яам, Хайнс Зайдалын сантай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын буланд 4 дугаарыг шинэ хуулиудийн сэдвээр, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 11 сарын дугаарыг “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-ийн сэдвээр тус тус бэлтгэн нийтэд хүргэлээ.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 32 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж өгч, хууль, эрх зүйн асуудлаар нийт 38 иргэн болон сумд, байгууллагуудад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлж, Дотоод удирдлагын системээр шинэ хууль тогтоомжийн 18 мэдээлэл оруулж, төрийн албан хаагчдыг хууль, эрх зүйн мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

Аймгийн Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж 2 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож тайлбар дүгнэлт гаргаж, 2 шүүх хуралдаанд оролцсон.

Хууль хэрэгжүүлэх асуудлаар сум байгууллагад зориулсан 2 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай хамтран гаргаж хүргүүлсэн.

“Авлигын эсрэг олон улсын өдөр”-ийг тохиолдуулан нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх зорилгоор “**Зөв зөвд шударга зөв**” соён гэгээрүүлэх аяныг 11 дүгээр сарын 20-ноос 14 хоногийн хугацаанд цахим орчноор дамжуулан олон нийтэд сурталчлан таниулах ажлыг 27 сум, төрийн байгууллагууд нэгдэн зохион байгуулж байна.

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс чиглэл ирсний дагуу 2020.11.08-нээс эхлэн Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, арга хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлж байгаа ажлын мэдээг аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Боловсрол Соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Байгаль орчин аялал жуучлалын газар, Төв чандмань ДЭХГ, Авто тээврийн төв зэрэг байгууллагуудаас авч нэгтгэн хүргүүлээ.

Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг 27 суманд хүргүүлж, 12 сум хэлэлцүүлэг зохион байгуулж 392 иргэнээс 327 саналыг авч, бодлогын баримт бичигт тусган ажиллалаа.

Архивын тасгийн чиглэлээр:

Архивын тасгаас төрийн архивын эх баримтаас үйлчилгээ үзүүлэх зорилгоор энэ сард 175 иргэний хүсэлтийг хүлээн авч 703 хуулбар хувь, 98 лавлагаа, 1796 хөмрөгийн 879 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлж, орон нутгийн төсөвт 1.0 сая төгрөг орууллаа.

2 хөмрөгийн 55 хадгаламжийн нэгжийн 3926 хуудас баримтын 22253 хүний нэр, 2997 заалтын тоо, 2997 тушаалын тоог мэдээллийн програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, 2 хөмрөгийн 55 хадгаламжийн нэгжийн 3926 хуудас баримт скайнердаж, 2 хөмрөгийн 55 хадгаламжийн нэгжийн 2997 заалтыг PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 2997 заалтын 3926 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 57671 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 10397, Газар өмчлөх эрхийн 47274 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 23569.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 163.1 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 168.3 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 5.2 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 381 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 153 нэмэлт өөрчлөлт, шинээр 11 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 0, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 35 бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 3 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 4 лавлагаа өгсөн. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого нийт 10.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлээр:

Аймгийн нутаг дэвсгэрт нийт 713 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 136 хэргээр буюу 16,01 хувиар буурсан. Гэмт хэргийн илрүүлэлт 55,8 хувьтай, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,3 хувиар өссөн.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа:

Эрүүлжүүлэх, саатуулах байранд гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-18, шүүхээр баривчлагдсан-35, албадан саатуулагдсан-7, ар гэрт нь хүлээлгэн өгсөн-3 нийт 63 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд код журмын дагуу биед болон эрүүл мэндийн үзлэг хийж хүлээн авч ажиллалаа.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” тогтоолын хэрэгжилтийг хангуулж Цагдаагийн газраас 180 албан хаагч бэлэн байдлын нэгдүгээр зэрэгт шилжин ажиллаж, Төв аймгийн 26 суманд 36 постод 114 албан хаагч, үндсэн 3 пост, хөдөлгөөнтөөр 2 чиглэлд нийт 4 албан хаагч 24 цагаар, Зуунмод суманд 10 хяналтын цэгт 10 албан хаагч 8 онцгой байдлын газрын 10 алба хаагчтай хамтран 2 ээлжээр 6 цагаар ээлжлэн 14 өдөр 3360 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, иргэдийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоон хяналт тавьж ажиллалаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 38 жолоочийг илрүүлж, 38 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 3 иргэнийг Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулсан. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 2682 жолоочийг 85.9 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 15 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатууллаа.

Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны чиглэлээр:

Энэ сард Криминалистикийн шинжилгээ-165, Нийт хийсэн магадлан шинжилгээ-177, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-591, гарын мөрийн санг баяжуулсан-360, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 697 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
11-р сар	321	353	43	631	364	267	57.8%
	4335531.9	3851249.8	1391884.1	6794897.6	2101911.6	4692986.0	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд:

Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр:

Аймгийн 2020 оны төсөвт тодотгол хийгдсэнтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт ажил төлөвлөгдөж 2020 онд нийт 40,814.2 сая төгрөгийн 126 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 37,785.8 сая төгрөгийн 97 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж хэрэгжүүлэхээс *(дэлхий нийтэд короновирус тархсантай холбогдуулан төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн яам, бусад шалтгаанаар төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч байгууллагын албан мэдэгдэл, шийдвэрээр 3,180.1 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээний тендерийг зогсоосон)* тайлан оны 11 дүгээр сарын гүйцэтгэл, өссөн дүнгээр 84 төсөл, арга хэмжээнд үнэлгээний хороог байгуулж, цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.

Тайлант оны 11 дүгээр сарын байдлаар худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 98%-тай байна.

Тендер зарлагдсан төсөл, арга хэмжээ:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 300.0 сая төгрөгийн 3 ажил
 - БХБЯамны эрх шилжүүлсэн төсөл
 - 3 дугаар өргөх станцын насос суурилуулах
 - БОАЖЯамны эрх шилжүүлсэн аймгийн төвийн хог хаягдлын бууруулах арга хэмжээ
 - ОБГазар зуншлага муу аймагт өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх
- Аймгийн төсвийн шилжих үлдэгдлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 20.0 сая төгрөгийн 1 ажил
 - Аймгийн Татварын хэлтсийн дотоод тохижилт, барилга засвар
- Аймгийн Засаг даргын нөөц сангаас хэрэгжүүлэх 35.0 сая төгрөгийн 1 ажил
 - Аймгийн өвс, тэжээлийн нөөцөд нийлүүлэх өвс.
- Гадаадын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 281.4 сая төгрөгийн 1 ажил
 - Зуунмод, Баян, Баянцагаан сумдын сургуулийн гал тогооны барилга засвар

Үнэлгээний хорооноос захиалагч байгууллагуудад гэрээ байгуулах дүгнэлт хүргүүлсэн төсөл, арга хэмжээ-гэрээ хийгдэхээр хүлээгдэж буй ажил:

1. Аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 101.9 сая төгрөгийн 2 ажил
 - Туул, Хэрлэн голуудын дагуу загас үржүүлэх, жимсний модны бут сөөг тарих үржүүлгийн газар байгуулах төслийн ТЭЗҮ-г мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ажил-28.3 сая төгрөг
 - Хөндөгдсөн эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлыг үргэлжлүүлэн, эзэнгүй орхигдсон талбайгаас 10га-д техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх ажил-73.6 сая төгрөг
2. Аймгийн төсвийн шилжих үлдэгдлийн санхүүжилт, хэрэгжүүлэх 930.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ
 1. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын авто машин

Захиалагч байгууллагаас ажлын даалгавар ирүүлсэн боловч тендер зарлах явцад гэрээ шууд байгуулахаар шийдвэрлэсэн ажлын гэрээ хийгдэхээр хүлээгдэж буй ажил:

1. ЕБС, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийг бусад хөрөнгө оруулагч нартай хамтран байгуулахад орон нутгийн оролцоо /Баянцогт, Өндөрширээт, Дэлгэрхаан, Цээл сумд/ төсөвт өртөг-140.0 сая төгрөг.

- 2.ЭМТөвүүдийг цэвэрлэх байгууламжтай болгоход дэмжлэг үзүүлэх орон нутгийн оролцоо /Төв, Угтаалцайдам сум/ төсөвт өртөг-18.5 сая төгрөг.

Цахим тендер зарлахаар хүлээгдэж буй ажил:

1. Гадаадын хөрөнгө оруулалтын санхүүжилтээр Зуунмод, Баян, Баянцагаан сумдын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж шинэчлэх -144.0 сая төгрөг Үнэлгээний хороо байгуулагдсан.

Аймгийн Хөрөнгө оруулалтын ажлын явц 74,5% үүнээс 2020 онд хийгдэх ажлын явц 90%-тай байна.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр:

Хэлтсийн үйл ажиллагааны хүрээнд: “Нийтийн аж ауйн талаар аймгаас баримтлах бодлого 2017-2024” –ын хүрээнд 2020 онд аймгийн хэмжээнд 25 сум төвлөрсөн халаалтын системд холбогдоод байна. Мөн 22 сумдын батлагдсан ерөнхий төлөвлөгөөг төслийн багт хүргүүлээд байна. Сүмбэр сумын соёлын төвийн дундын гүйцэтгэлийг баталгаажуулсан. БХБЯмнаас БХТөв, ГХБХБГазрын цахим уулзалтаар УТХоруулалтаар баригдаж ашиглалтад орж амжаагүй барилга байгууламжийн санхүүжилт болон ашиглалтад энэ ондоо багтаж оруулах шаардлагатай барилгуудын талаар хэлэлцсэн.

Зуунмод сумын 47, 48-р байрнуудын гадна тохижилт, авто замын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Мөн 46-р байрны гадна тохижилтын ажлыг “ТӨВ АЗЗА” ТӨХК-тэй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлж ажлын явц 90 хувьтай хэрэгжиж байна.

Барилга захиалагч, хяналтын чиглэлээр: Сүмбэр сумын соёлын төвийн дундын гүйцэтгэлийг баталгаажуулсан. БХБЯАМ-ны Хөрөнгө оруулалт үйлдвэрлэлийн хэлтэсд Төв аймгийн Зуунмод хотын “Үерийн ус зайлуулах байгууламжийн ажил “Ковид-19” цар тахлын улмаас гүйцэтгэгч компани цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон тул гэрээний хугацааг сунгаж, барьцаа хөрөнгийн дансанд үлдэгдэл хөрөнгийг байршуулах талаар албан бичиг хүргүүлсэн.

Ерөнхий архитекторын үйл ажиллагааны хүрээнд: Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2020 онд 69 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан батлаж, 49 зураг төсөл зөвшөөрөлцсөн. Мөн нийт 96 барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгож ажилласанаас энэ сард 18 зөвшөөрөл олголоо.

Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хүрээнд энэ сард 9-н барилга байгууламжид комисс ажиллан үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулсан байна.

Хот байгуулалтын кадастрын чиглэлээр: Хот байгуулатын кадастрын мэдээллийн сангийн инженерийн шугам сүлжээний мэдээллийн санд цэвэр усан хангамжийн төв магистрал шугамыг бүртгэн оруулж байна.

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн оновчтой бүтэц, нийгмийн хөгжлийн загварыг боловсруулах төслийн баг Зуунмод, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Угтаалцайдам, Лүн, Аргалант, Сэргэлэн, Эрдэнэ сумдад ажилласан. Мөн 22 сумдын батлагдсан ерөнхий төлөвлөгөөг төслийн багт хүргүүллээ.

Хот байгуулатын кадастрын мэдээллийн санд 2020 оны байдлаар 19 барилга байгууламж бүртгэгдэж 10 сард 2 барилга байгууламж бүртгээд байна.

Мөн 10 сарын байдлаар Зуунмод сумын 40 амины орон сууц, 5 орон сууцны барилга, боловсролын 2 барилга байгууламжийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэн орууллаа.

Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд энэ онд нийт 65 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан батласан бөгөөд үүнээс энэ сард 2 архитектур төлөвлөлтийн даалгавар аж ахуйн нэгжид олгосон. Мөн 48 зураг төсөл зөвшөөрөлцсөнөөс энэ сард 7 барилгын зураг төсөл зөвшөөрөлцлөө.

Газрын харилцааны чиглэлээр:

Газрын төлбөр: Газрын төлбөр: 2020 оны 11 дүгээр сарын байдлаар газрын төлбөрийн орлого 2,832,218.1 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2,657,859.8 мянган төгрөгийг төвлөрүүлж 93.8%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 297,780.64 мянган төгрөг дутуу төлөлтөөс, 580,235.6 мянган төгрөг дуудлага худалдаанаас төвлөрсөн.

27192 иргэний өмчилсөн газрын үл хөдлөх хөрөнгийн албан татварыг ногдуулсан. Мөн 2885 газар эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдийн газрын төлбөрийн нэхэмжлэлийг үүсгэн нийт 9452 нэгнталбарт хүргүүлж, 16 сумын 248 нэгж талбарт дуудлага худалдааг зохион байгууллаа.

Газар зохион байгуулалт: Газар зохион байгуулалтын цахим системийн сургалтыг 27 сумын газрын даамлуудыг хамруулан зохион байгууллаа. Монгол улсын иргэнд 2021 онд эзэмшиж буй газрыг 1341 иргэнд 111,2 га, шинээр 3596 иргэнд 583,6 га, улсын чанартай зам дагуу 540 иргэнд 43,8 га газар нийт 5477 иргэнд 738,6 га газрыг өмчлүүлэх саналыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар оруулж, дэмжигдэн холбогдох байнгын хороонд хүргүүллээ.

Геодези: 27 сумын төв суурингийн байрзүйн зургийг Монгол улсын MNS 6702:2017 стандартад бүрэн хөрвүүлж дуусган ГЗБГЗЗГазарт хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд 2020 онд гүйцэтгэлээр хүлээж авсан байрзүйн зургийг 192.168.10.37 сэрвер дээр баяжилтийг хийж дуусгасан. Хаягийн зургийн баяжилтийг 192.168.15.216 сэрвэрт хандан өөрчлөлтийг дуусгасан.

Газрын кадастр: “Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэн засварлаж, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбох үйлчилгээнд нэвтрүүлэх ажлын заавар”-ын 4.1.8, 4.2.22 дахь заалтын дагуу сумдуудын ЗДТГ-ын архивт хадгалагдаж байгаа нэгж талбарын хувийн хэргийн цаасан суурьтай баримтыг Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын төрийн архивт татан авахтай холбогдуулан 26 сумын хэмжээнд 327369 хуудас 55863 өмчлөлийн нэгж талбарын хувийн хэрэг, 1138 хадгаламжийн нэгжид байгаа ба 26 сумын хэмжээнд 373787 хуудас 40830 эзэмшилийн нэгж талбарын хувийн хэрэг, 1562 хадгаламжийн нэгжид байгаа судалгааг гаргаж Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газарт хүргүүлээд байна.

Орон нутгийн өмчийн чиглэлээр:

Сумдын болон төсөвт байгуулагын хөрөнгө шийдвэрлүүлэхээр ирүүлсэн 2 барилга байгууламж, 15 тээврийн хэрэгсэлийг дуудлагын худалдаа болон, сэлбэгээр худалдахаар 1,9 тэрбум төгрөгийн хөрөнгийг балансаас балансад, 81,0 сая төгрөгийн хөрөнгийг акталаж устгах саналыг хууль, журмын дагуу судлан нэгтгэж боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд өргөн барьлаа.

Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 13 өрх нийт 25 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулснаар сарын төлбөрийг график хугацааны төлөлтөнд хяналт тавьж ажилласнаар 2019 оны

19,078,000, 2020 оны 43,000,000 төгрөг буюу нийт 62,000,000 төгрөгийг төвлөрүүлсэн байна. Мөн 2020 онд Түрээсийн орон сууцанд хамрагдахыг хүссэн 130 иргэдийн өргөдлийг бүртгэлээ.

Аймгийн Ахмадын хороо шинэ байранд орсонтой холбогдуулан ахмадын хорооны ашиглаж байсан барилгыг хүлээн авч, түрээслэх зарыг зарлан явуулж, 5 түрээслэгчтэй түрээсийн гэрээг байгууллаа.

Зам харилцааны хүрээнд:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Зуунмод сумын хуульчдын хотхоны 0.4 км авто замыг байнгын ашиглалтад хүлээн авч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нээлээ. Замын барилгын ажлыг “Хишиг Буянт зам” ХХКомпани гүйцэтгэлээ.

Хуульчдын хотхоны авто зам: хөдөлгөөний 2 зурвастай 11 метрийн өргөн далан, 6 метрийн өргөн зорчих хэсэгтэй төлөвлөгдөж баригдлаа.

Газар тариалангийн хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2020 онд үр тариа 67437 га үүнээс буудай 61213 га, төмс 10916 га, хүнсний ногоо 1636 га, таримал тэжээл 25415 га, тосны ургамал 17212 га нийт 122616 га талбайд тариалалт хийсэн.

Намрын ургац хураалтын үед их хэмжээний цас хур тундас орсноос 11036 га ургац алдаж, 9346 га тэжээлд шилжиж үр тариа 54536 га-аас 67955 тн буюу нэгжээс 12.4 цн; төмс 10176 га-аас 152200.8 тн буюу 149.6 цн; хүнсний ногоо 1496 га-аас 21759.7 тн буюу нэгжээс 145.4 цн; тэжээлийн ургамал 33334 га-аас 89930 тн буюу нэгжээс 27.0 цн; тосны ургамал 11572 га-аас 5721.4 тн буюу нэгжээс 4.9 цн нийт 337.5 мян тонн ургац хураан авлаа.

Улаанбуудайн урамшуулалын материалыг цахим болон цаасан хэлбэрээр хүлээн авч нэгтгэл, боловсруулалт хийгдэж байна.

Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-с БНХАУ руу чиглэсэн байгалийн хийн хоолой байгуулах төслийн хүрээнд хийн хоолойн шугамын трасс тогтооход УБ төмөр замын трассаас баруун, зүүн тийш 100 км байрлах хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн барилга, усжуулалтын байгууламж, тариалангийн газар, усан сангийн судалгааг Батсүмбэр, Баян, Баяндэлгэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант Сүмбэр, Сэргэлэн, Зуунмод сумдаас авч ХХААХҮЯаманд хүргүүлээ.

Мал аж ахуйн хүрээнд:

Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд малчин өрхийн өвөлжилт 93.5 хувь, малчдын өвс, тэжээл 66.4 хувь, малын усан хангамж 99.7 хувь, малчин өрхийн хашаа бууцны хангамж 98.5 хувь, аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт 80.3 хувь, сумдын өвс тэжээлийн аюулгүйн нөөц 10.3 хувь, нийт аймгийн мал аж ахуйн өвөлжилт 80.0%-тай хангагдсан байна.

Малын отор нүүдлээр аймаг дотроо 545 өрхийн 404426 мал, Өвөрхангай, Дундговь, Баянхонгор, Говь-Алтай зэрэг аймгуудаас 398 өрхийн 363528 мал, гадны аймаг, сумдад 111 өрхийн 75122 мал, аймаг дундын отрын бүс нутгуудад 155 өрхийн 139826 мал, сум дундын отрын бүс нутагт 70 өрхийн 50133 мал нийт **1279 өрхийн 1033035 толгой мал** отроор өвөлжиж байна.

Аймгийн аюулгүйн өвс тэжээлийн нөөцөд өвс, тэжээл бэлтгэн нийлүүлэх аж хуйн нэгж, иргэн сонгон шалгаруулах тендерийн техникийн тодорхойлолт, холбогдох баримт бичгийг ОНӨГазарт хүргүүлж, 12 дугаар сарын 18 ний өдөр шалгаруулахаар шийдвэрлэлээ.

Алтанбулаг, Баян, Баянцагаан, Баян-Өнжүүл Лүн сумдын 12.900 толгой малд намрын үзлэг, ангилалтыг хийсэн тайланг ХХААХҮЯаманд хүргүүлээ.

Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд:

Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдын үйлдвэрлэсэн гарал үүсэл нь баталгаажсан, эрүүл ахуйн шаардлага хангасан мах, сүү цагаан идээ, хүнсний ногоог аймгийн хүн амын хэрэгцээнд зориулан дундын дамжлагагүй, шууд худалдан авалт хийх, үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих зорилгоор “**Нэг сум- нэг бүтээгдэхүүн 2020**” үзэсгэлэн худалдаа 3 өдрийн турш зохион байгуулж, 24 сумын 180 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид оролцож, 245.0 сая төгрөгийн борлуулалтаар дэмжин, 11 номинациар шалгаруулах ажлыг зохион байгууллаа.

Ковид цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан Хүнс хангалтын анги бүрэлдэхүүн ажиллаж “*Аймгийн хэмжээнд хүнсний аюулгүй байдалд алдагдах үед хариу авах арга хэмжээний төлөвлөгөө*” боловсруулан, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг өдөр бүр сумдаас авч нэгтгэн, нөөцийг нэмэгдүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулан ажиллалаа.

Махны үнэ өсөх, хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлж аймгийн төвийн хүн амын хэрэгцээнд зориулан Зуунмод сумын 25 худалдааны цэгээр төмс -10.2 тонн, хүнсний ногоо 4.9 тонн, 9 цэгээр ангилаж савласан хонины мах 2 тонн үнэ нэмэхгүй шууд борлуулах нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын нөөц сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 20.9 сая төгрөг зарцууллаа. / *Төмс 500 төгрөг, байцай, лууван 800 төг хонины мах /3кг ангилж савласан/:* 1 кг нь 6500 төг/. Хүнсний гол нэийн бүтээгдэхүүний үнэ ханш, нийлүүлэлт хангалтын байдалд хяналт хийх, худалдаа эрхлэгчдэд тулгарч байгаа санал авах ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажиллаж, 25 хүнсний дэлгүүрийг хамруулан илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч “Мэдэгдэл хуудас” хүргүүлэн ажиллалаа.

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “*Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам*”-ын дагуу хөнгөлттэй зээл сонгон шалгаруулах аймгийн Дэд хорооны хурлаар 13 аж ахуй нэгжийн 1.2 тэр бум төгрөгийн төсөл хэлэлцүүлэх ажлыг зохион байгууллаа. Дэд хорооны хурлын шийдвэрээр I ээлжинд 6 аж ахуй нэгжид 500.0 сая төгрөг, II ээлжинд 7 аж ахуй нэгжид 700.0 сая төгрөгийн зээл олгохоор эрэмбэлэгдэж, аймгийн Засаг даргын А/553 захирамжаар баталгаажуулж ХХААХҮЯ-ны ЖДҮГазарт хүргүүллээ.

Мал эмнэлгийн үйлчилгээ:

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1803.6 мян/мал хамруулахаар Биокомбинат УТҮГ-тай гэрээ байгуулж, вакцины нийлүүлэлт 100%, вакцинжуулалт 99.3 хувьтай байна. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт намрын дархлаажуулалтын ажлыг 7 суманд эхлүүлэн 98.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Мал эмнэлгийн цахим гэрчилгээг 33691 олгож, дуудлагын дагуу 1732 үйлчилгээ үзүүллээ.

Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хамтарсан баг “Мал-Мах” аян хэрэгжүүлж Алтанбулаг, Баяндэлгэр, Лүн, Сэргэлэн, Эрдэнэ, Эрдэнэсант сумдын мал нядалгааны цэг, мах боловсруулах үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийж ажиллалаа.

“Ногоон алт-Малын эрүүл мэнд” төслийн санхүүжилтээр Сүмбэр сумын “Таван буянт ирээдүйн хөгжил” МЭҮНэгж стандарт хангасан загвар мал эмнэлгийн үйлчилгээний барилгын ажлыг эхлүүллээ.

Франц улсын Монтебиллярд үүлдрийн 96 толгой үхрийг Аргалант сумын нутагт хүлээн авч халдвар хамгаалал, хорио цээрийн дэглэмд оруулан хэл хөхрөх, арьсны товруу, сүрьеэ, лейкоз, шүлхий, бруцеллэз, тархи сархиатах өвчний шинжилгээний дээж авах малын эмч нарын баг ажиллалаа.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг нь 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа 1489 тээврийн хэрэгсэл, 60142 толгой мал, 1920.3 тн мах, махан бүтээгдэхүүн, 58167 ширхэг арьс шир, 71 тн ноос, 200 кг, ноолуур, 24,4 тн цагаан идээний эрүүл ахуй болон мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийж, зөрчилтэй 21 тээврийн хэрэгсэл илрүүлж, арга хэмжээ авч ажиллалаа.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээ:

Тохирлын гэрчилгээ шинээр авах, сунгуулах 74 иргэн аж ахуй нэгжийн бүтээгдэхүүн үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулж 30 үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олголоо. Аргалант, Заамар, Сэргэлэн, Цээл сумын 49 худалдаа үйлчилгээний цэг, 6-н шатахуун түгээх станцын нийт 83 хэмжих хэрэгслийг шалган баталгаажуулах ажлыг зохион байгуулан, стандарт мэдээлэл лавлах үйлчилгээг 24 иргэн аж ахуйн нэгжид цахимаар үзүүллээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:

Ойн бодлогын талаар: Аймгийн Засаг даргын 2020 оны 10 сарын 19-ний өдрийн А/524 дүгээр захирамжийн дагуу аймгийн нутаг дэвсгэрт улс болон орон нутгийн төсвөөр, мод бэлтгэлийн аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр 2020 онд хийсэн ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлын гүйцэтгэлийг 11 сарын 03-06-ны хооронд шалгалтыг зохион байгуулан ажиллаа.

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөгдсөн Мөнгөнморьт суманд 40 га-д, Батсүмбэр суманд 20 га-д байгалийн сэргэн ургалтад туслах ажил, Алтанбулаг суманд бургасан ойн 10 га-д, Борнуур суманд Сүжигтэд 10 га-д хийх ойжуулалтын ажлууд санхүүжилт нь шийдэгдээгүй хийгээгүй байна. Ойн хайгуул ХХК Батсүмбэрт 30 га ойжуулалт, Баянцогтод 10 га-д байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийсэн.

Орон нутгийн төсвөөр хийгдэхээр төлөвлөсөн ажлаас Мөнгөнморьт суманд Гутай нөхөрлөл байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг Их Гутайн адагт 30-гад хийсэн. Тус газарт 25 м * 25 м 2 жишиг талбай сонгон тооллого хийхэд 1 га-д 230-235 ширхэг тарьц тарьсан байна

Батсүмбэр суманд 5 ААН өөрийн хөрөнгөөр ААН 47 га, 2 нөхөрлөл 2 га-д ойжуулалт хийсэн байна. “Хатуу хөл хорионы дэглэм”-д шилжсэнтэй холбогдуулан сум дундын ойн анги, сумын БОХУБ нар тооллого хийсэн.

Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд: 2020 оны 11 дүгээр сарын 02-ны “Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай” тогтоолын дагуу эрүүгийн 203400000605, 203400000607 дугаартай хэрэгүүдэд шинжээчээр ажиллаж, хууль бусаар бэлтгэсэн гэх моднуудыг БОАЖГ, Эрдэнэ сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч нарын хамт үзлэг, хэмжилт хийж шинжээчид тавьсан асуултанд хариулж, дүгнэлт гарган ажиллаа.

Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр:

Төв аймгийн 2020 оны 10-р сарын цаг уурын тойм

Агаарын дундаж температур: нийт нутгаар $-3.6^{\circ}\text{C} \dots +0.6^{\circ}\text{C}$ байснаас Эрдэнэ суманд -3.6°C , Лүн суманд 0.6°C байлаа. / Зураг-1/ **Олон жилийн дундажтай харьцуулахад:** нийт нутгаар дунджаас $0.5^{\circ}\text{C} - 2.2^{\circ}\text{C}$ -ээр хүйтэн байлаа. / Зураг-2/



/ Зураг-1/




/ Зураг-2/

Хөрсөнд дундаж температур: нийт нутгаар $-2^{\circ}\text{C} \dots +2^{\circ}\text{C}$ байснаас Эрдэнэ сумданд -2°C , Лүн, Заамар, Цээл сумдад $+2^{\circ}\text{C}$ байлаа.


Агаарт 30°C -аас дулаан өдөр нийт нутгаар ажиглагдаагүй. Хөрсөнд 40°C -аас дээш халсан өдөр нийт нутгаар ажиглагдаагүй.

Агаарын температурын үнэмлэхүй их утга $11.3^{\circ}\text{C} \dots 18.3^{\circ}\text{C}$ байснаас Өндөрширээт сумданд 18.3°C , **хөрсөнд үнэмлэхүй их утга** $14^{\circ}\text{C} \dots 34^{\circ}\text{C}$ байснаас Баянцагаан суманд 34°C ажиглагдсан бол **агаарт үнэмлэхүй бага утга:** $-16.0^{\circ}\text{C} \dots -8.5^{\circ}\text{C}$ байснаас Цээл суманд -16.0°C , **хөрсөнд үнэмлэхүй бага утга:** $-19^{\circ}\text{C} \dots -9^{\circ}\text{C}$ байснаас Угтаал суманд -19°C ажиглагдлаа.

Тунадасны хувьд: Нийт нутгаар 0.2-16.8 мм тунадас орсон, хамгийн их нь Борнуур суманд 16.8 мм, хамгийн бага нь Алтанбулаг суманд 0.2 мм орсон. / Зураг-3/



/ Зураг-3/



/ Зураг-4/

Олон жилийн дундажтай харьцуулахад: Баянчандмань, Борнуур, Баянжаргалан, Бүрэн сумдад дунджаас ахиу, Батсүмбэр суманд дундаж орчим бусад сумдад дунджаас бага хур тунадас орсон. / Зураг-4/

Салхины дундаж хурд: нийт нутгаар 1.7-4.2 м/с байснаас Зуунмод, Баянжаргалан, Дэлгэрхаан сумдад 4.1- 4.2 м/с, Мөнгөнморьт, Жаргалант сумдад 1.7-1.8 м/с байв. **Салхины их хурд:** 12-28 м/с байснаас Бүрэн суманд 28 м/с хүрч салхилсан. **10 м/с-ээс их хурдтай өдрийн тоо:** 3-16 өдөр байснаас Зуунмод, Бүрэн, Баянжаргалан, Дэлгэрхаан сумдын нутгаар 15-16 өдөр байлаа.

Харьцангуй чийг: нийт нутгаар 47%-73% байснаас Баянцагаан суманд 47%, Мөнгөнморьт, Жаргалант суманд 71%-73% байлаа.

Урьдчилан мэдээлэх: Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм мэдээг тус тус гаргаж, И-мэйл-ээр дамжуулж, www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, төв талбай болон байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна. Цас орж, цасан шуурга шуурах тухай анхааруулах мэдээ /АМ/-г 11 дүгээр сарын 05-нд 2 удаа, 17-19-ний өдрүүдэд тус бүр 1 удаа 12-48 цагийн өмнө www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, Facebook, TuvTsaguur page-д, Дотоод удирдлагын системийн олон нийтэд байршуулж, аймгийн хэрэглэгчдэд хүргэж үйлчиллээ.

Байгаль орчны шинжилгээний лаборатори: Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 42 удаа ажиглалт хийсэн ба хүхэрлэг хийн дундаж агууламж 0.017 мг/м^3 азотын давхар ислийн дундаж агууламж 0.016 мг/м^3 үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүхэрлэг хийн дундаж агууламж 0.009 мг/м^3 -ээр, азотын давхар ислийн дундаж агууламж 0.005 мг/м^3 -ээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Гадаргын усны чанар: Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 11 дүгээр сард Туул-Лүн, Туул-Заамар голуудын хяналт шинжилгээний цэгээс усны сорьц авч химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойллоо. Шинжилгээний дүнгээс үзэхэд голын усны эрдэсжилтүүд 201-417 мг/мл байсан, голын ус органик бодисын болон эрдэс азотын бохирдолгүй цэвэр байна.

Ус судлалын салбар: Төв аймгийн нутаг дэвсгэрт 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2020 оны 11 дүгээр сарын 24-ний байдлаар усны түвшин Туул гол Туул-Алтанбулаг харуулд -520 см, Туул-Лүн харуулд-141 см, Туул-Заамар харуулд 180 см, Хэрлэн голын усны түвшин Хэрлэн-Хонгон харуулд 135 см, Хэрлэн-Мөнгөнморьт харуулд 97 см, Сөгнөгөр голын түвшин Сөгнөгөр-Сөгнөгөр харуулд 197 см, Шивэрт гол Шивэрт-Борнуур харуулд 129 см тус тус байна. 2019 оны мөн үетэй нь харьцуулахад Туул гол 11-18 см-

ээр их, Хэрлэн гол 0-12 см-ээр бага, Сөгнөгөр гол Сөгнөгөр-Сөгнөгөр харуулд 6 см, Шивэрт гол Шивэрт-Борнуур харуулд 9 см -ээр тус тус бага байна.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр Жендэрийн үндэсний хорооноос 21 аймаг 9 дүүргийн нийгмийн бодлогын хэлтсийн дарга нар болон аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга нартай цахим уулзалт зохион байгуулж, жил бүр зохион байгуулагддаг жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг Ковид нүүрлэсэн энэ цаг үед “Өрх гэр, ажлын байр, олон нийтийн газарт: Яг одоо жендэрт суурилсан хүчирхийллийг цэглэе! уриан дор нэгдэн олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан цахим орчинд зохион байгуулахаар шийдвэрлэлээ. Энэ хүрээнд 11 дүгээр сарын 25-ны өдөр Аймгийн Засаг дарга аймгийн орон нутгийн телевизийн цахим шууд нэвтрүүлэгт оролцон Төв аймаг уг аянд нэгдэж байгаагаа илэрхийлэн, уг аянд нэгдэхийг иргэдэдээ уриаллаа.

Боловсролын салбар:

1. 11-р сарын 11-ий өдрөөс улс орон даяар зарласан Ковид-19 цар тахлаас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх Улсын онцгой байдлын тогтоол шийдвэрийн дагуу Бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргасан. Хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон хугацаанд сургалтын хөтөлбөрийг тасалдуулахгүй байх зорилгын үүднээс теле хичээл болон цахим хичээл зохион байгуулах, цахим хичээлд сурагчдыг хамруулах арга хэмжээ авч ажиллаж байна.
2. Угтаалцайдам, Цээл сумдын сургууль цэцэрлэгт зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, сум орон нутгийн 4 удирдах ажилтан, 52 багш, 1042 сурагч, 52 эцэг эх, иргэдэд боловсролын үйлчилгээ үзүүлсэн.
3. Цээл суманд нээлттэй хаалганы өдөрлөгөөр 26 багш, 12-р ангийн 25 сурагч, 26 эцэг эхэд ЭЕШ-д бэлтгэх тааар сургалт зохион байгуулж, сурагчдаас ЭЕШ-ын сорилын шалгалт авч газар дээр нь багш сурагч эцэг эх иргэдийг байлцуулан машинаар уншуулж дадлага ажил хийлээ.
4. “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитад ерөнхий боловсролын 31 сургуулийг хамрууллаа.
5. Онцгой байдлын үед шаардлагатай өрөө тасалгааны нөөц болон сургууль, цэцэрлэгийн хүнсний үлдэгдлийн судалгааг гаргаж аймгийн онцгой байдлын газарт хүргүүллээ.
6. “Аймгийн боловсролын тогтвортой хөгжлийн бодлого”-ын хоёр дахь шатны төлөвлөгөөний төсөл гаргаж НБХ-г хүргүүлсэн.
7. Насан туршийн боловсролын Үндэсний төвөөс аймгуудын НТБ-ын багш нарыг чадавхжуулах Цахим онлайн сургалт зохиогдлоо. Төв аймаг, Дорноговь аймгийн 55 багш 100% хамрагдлаа.

Монгол туургатан театр:

1. 2020 оны 11-р сарын 02-нд “Хэлгүй жим” уран сайхны киногоор 200 хүүхдэд үйлчилсэн.
2. 2020 оны 11-р сарын 02-ны өдөр Бүрэн сумын холбооны шинэ байрны нээлтийн арга хэмжээнд урлаг соёлын арга хэмжээгээр оролцсон.
3. 2020 оны 11-р сарын 06-нд “Сондор” монголын уран сайхны киногоор 300 хүүхдэд үйлчилсэн.
4. 2020 оны 11-р сарын 05-ны өдөр Спортын ордонд зохион байгуулагдсан Ширээний теннисийн аваргын тэмцээний нээлтийн арга хэмжээнд оролцлоо.
5. 2020 оны 11-р сарын 06-ны өдөр Солонго цогцолборт “Нэг сум-Нэг бүтээгдэхүүн” арга хэмжээний хаалтын үйл ажиллагаанд уран бүтээлээр оролцсон.
6. Монгол туургатан театрын уран бүтээлчид болон захиргаа аж ахуйн албан хаагчид 2020 оны 11-р сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Алтан намар” хөгжмийн арга хэмжээний бэлтгэл ажлыг хангасан.
7. 2020 оны 11-р сарын 02-10 хооронд хүүхдийн хөгжмийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд Зуунмод сумын Ерөнхий боловсролын 6 сургууль, 8 цэцэрлэгийн 1751 хүүхдэд хөгжмийн тоглолтыг хүргэсэн.

8. Монгол туургатан театрын драм, хөгжим, дуу, бүжиг ангийн уран бүтээлчид хөл хорионы үед Соёлын яамнаас зохион байгуулсан “Цахим орчинд соёл түгээе, би хариуцлагатай иргэн” аянд нэгдэж тусгай хуваарийн дагуу цахимаар тоглолтуудыг гэр гэрээсээ зохион байгуулж нийт 200000 гаруй иргэнд соёл урлагийн арга хэмжээг хүргэж ажилласан. /хандалтаар/

Нийтийн номын сан:

1. Зуунмод сумын ХЦБС-ийн 387 хүүхэд багачуудад 2020 оны 10 дугаар сарын 23-аас 11 дүгээр сарын 10-ны хооронд “Үлгэрийн цаг”, чанга уншлага зохион байгуулж, 40 сурагчид 67 номоор зөвөрийн номын сангийн үйлчилгээ үзүүллээ.
2. Соёлын яамнаас уриалж буй "Цахим орчинд соёл түгээе" аянд Төв аймгийн нийтийн номын сан нэгдэж Д.Нацагдоржийн уран бүтээлүүдээс толилуулаж номын сангийн page хуудсанд сурталчилсан.
3. Иргэдэд үйл ажиллагаагаа цахимаар хүргэх зорилгоор <http://library.to.gov.mn> сайтыг тогтмол ажиллуулж, 2020 оны 11-р сард үйл ажиллагааныхаа талаар нийт 1 удаагийн мэдээ, FACEBOOK group хаягаар 106 мэдээ мэдээлэл, видео оруулсан байна.

Биеийн тамир спортын газар:

1. Төв аймгийн цагдаагийн газрын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн 2020 оны 11-р сарын 07 –ны өдөр зохион байгуулж, тэмцээнд 8 багийн 72 тамирчин оролцлоо.
2. 2020 оны Фут заалны аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 11-р сарын 07-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 20 сумын 160 тамирчин оролцлоо.
3. Гроунд гольфын аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 11-р сарын 06-ны өдөр зохион байгууллаа. Тэмцээнд Зуунмод сумын 6 багийн 32 тамирчин оролцсоноос 15 эмэгтэй 17 эрэгтэй тамирчин оролцлоо
4. Чингис хаан шинэ нисэх онгоцны буудлын сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 11-р сарын 06-нд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 15 багийн 165 тамирчин оролцсоноос 44 эмэгтэй 121 эрэгтэй тамирчин оролцлоо.
5. 2020 оны ширээний теннисний төвийн бүсийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээн 2020 оны 11-р сарын 04-05-ны өдрүүдэд амжилттай явагдаж дүнгээ гаргалаа.Тэмцээнд Төв аймаг, Дархун Уул аймаг, сэлэнгэ аймаг, Дундговь аймаг, Өмнөговь аймгийн 233 тамирчин оролцсоноос 121 эмэгтэй,112 эрэгтэй тамирчин оролцлоо.
6. Зүүн бүсийн багш сурагчдын спортын бага наадам 2020 оны 12 сарын 01-ний өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 6 сумын 6 багийн 252 тамирчин оролцсоноос 60 эмэгтэй 200 эрэгтэй тамирчин оролцлоо.

Нийгмийн даатгалын хэлтэс:

1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурал 1 удаа хуралдаж, нийт 52 иргэний асуудал хэлэлцсэнээс шинээр 5 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 40 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 7 иргэнийг цуцаллаа.
2. Аймгийн хэмжээнд 14901 тэтгэвэр авагчдад 5.6 тэрбум ₮-ийн тэтгэвэр олголоо.
3. ЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 484 дүгээр тогтоолоор баталсан “Зарим иргэний тэтгэврийн нэмэгдүүлэхэд баримтлах журмын дагуу нийт 1493 тэтгэвэр авагчдад 74.8 сая ₮-ийн нэмэгдэл олгоод байна.
4. Хүмүүн ахлах, дунд сургууль, Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Ирээдүй цэцэрлэг, Цахилгаан эрчим хүчний газар нийт 5 байгууллагын 136 иргэн даатгуулагчдад "Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, түүнд орсон нэмэлт өөрчлөлт нийгмийн даатгалын цахим үйлчилгээ" сэдвээр сургалт зохион байгууллаа.
5. Ковид-19 халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр МУ-ын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын хэлтэст хариуцлагатай жижүүрүүд ажиллан нийт 1100 гаруй иргэн даатгуулагчдад зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллалаа.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар:

Хүүхэд хамгааллын чиглэлээр:

1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлэх тухай ГБХЗХГ-ын даргын А/74 дугаар тушаалаар 15 айл өрхөд үзүүлэх тусламжийн нөөц бүрдүүлж, хүнс, амин дэм, эрүүл ахуйн бүтээгдэхүүний тусламж 13 өрхөд хүргээд байна.
2. Аймгийн хэмжээнд “Хайраар дүүрэн богц” аян өрнүүлэн ажиллаж байна. Зуунмод сумын хүнсний нэр төрлийн 7 дэлгүүрт аяны богц байршуулан цугларсан бараа бүтээгдэхүүнийг тусламж дэмжлэг

шаардлагатай айл өрхүүдэд түгээн ажиллаж байна. Аянд 420.0 мян ₮-ийн бараа бүтээгдэхүүн цугларч 13 өрхийн 48 хүүхдэд хүргэлээ. Номт ротари клуб 250.0 мян, аймгийн ЗДТГ, ТАСЗ-ийн Төв аймаг дах салбар зөвлөл 200.0 мян ₮, нийт 450.0 мян ₮-ийн бэлэн мөнгө цугласныг ХБХ-тэй залуу гэр бүл, түлээ нүүрс шаардлагатай зорилтот өрхүүдэд дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна.

3. Аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар, ГБХЗХГ хамтран “Хүчирхийлэлгүй гэр бүлийн төлөө хамтдаа” аяныг 2020.11.05-аас 12.05-ыг хүртлэх хугацаанд зохион байгуулан ажиллаж байна.
4. Цаг үеийн асуудал болон эрсдэлт нөхцөл дэх хүүхдүүдийн талаарх мэдээллийг Төв, TBS телевизүүдэд 2 удаагийн ярилцлага өглөө.
5. Сумдын Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн сэтгэл зүйн байдал дүн шинжилгээ хийж, түүнийг урлагаар тайвшруулж сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх аргад суралцуулах зорилгоор “Урлагийн сэтгэл засал” сургалт зохион байгууллаа. Сургалт 2020 оны 11 сарын 04-06-ны өдрүүдэд ГБХЗХГазарт зохион байгуулагдаж, Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбооны тэргүүн В.Бэрцэцэг, нийгмийн ажилтан А.Батчимэг нар удирдан явуулсан. Сургалтад сумдын хамтарсан багийн нарийн бичгийн дарга-8, гишүүн бөгөөд сургуулийн нийгмийн ажилтан-6, ГБХЗХГазрын дарга болон 4 мэргэжилтэн, ЭМГ-ын сэтгэл зүйч-1, Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Төв ОНХ-ийн ажилтан-1, нийт 20 хүн хамрагдлаа. Түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд сургалтын зардалд ГБХЗХГ-аас 1.8 сая ₮, ДЗМОУБ-ын Төв ОНХ-өөс 2.5 сая ₮ зарцууллаа.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар:

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ

1. 2020 оны 11-р сарын байдлаар 1924 иргэнд 4894.2 сая ₮-ийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1535 иргэнд 1164.4 сая ₮-ийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1175 иргэнд 743.4 сая ₮-ийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 3247 ахмад настанд 518,4 сая ₮-ийн хөнгөлөлт тусламж, 5412 ахмад настанд 860.2 сая ₮-ийн насны хишиг, 664 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 169.8 сая ₮-ийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 6845 иргэнд 1409.1 сая ₮, жирэмсэн 1992 эхэд 832.5 сая ₮-ийн тэтгэмж, алдар цолтой 61 ахмад настанд 111.6 сая ₮, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 6100 эхэд 2693.0 сая ₮-ийн тэтгэмж, Өрх толгойлсон 313 эх /эцэг/-т 316.4 сая ₮, 2 ихэр хүүхэд төрүүлсэн 18 эхэд 36.0 сая ₮, алдарт эхийн 1, 2-р одонтой 9112 эхэд 1189.9 сая ₮-ийг тус тус олгосон.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүүхдийн мөнгийн талаар:

2. Өрхийн мэдээллийн нэгдсэн санд шинэ төрсөн 122 хүүхдийн мэдээлэл бүртгэсэн. Өрхийн судалгаанд хамрагдах 16 иргэнээс хүсэлт ирсэн бөгөөд 11 өрхөөр орж судалгааг авч оноо бодуулахаар дээд газарт уламжилсан. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 1208 өрхийн 362 иргэн 3483 хүүхдэд үзүүллээ. Цаасан эрхийн бичгийн үйлчилгээ авч буй 5 сумыг цахимд бүрэн шилжүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар:

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол нийгмийн хамгааллын салбар комиссын хуралдаан 11-р сард 1 удаа хуралдаж 7 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, хөгжлийн бэрхшээлийг тогтоосон. Бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбоотойгоор 2-оос дээш хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийн судалгаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон судалгаа, байнгын ажлын байртай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аймгийн хэмжээний судалгааг гаргаж судалгаа мэдээллийн сантай болсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан:

1. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 61 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 35 ажил олгогч байгууллага, иргэн, 170 сул чөлөөтэй ажлын байр, 124 ажилд зуучлагдсан иргэн, 69 шинэ /байнгын болон түр/ ажлын байрны мэдээллийг мэдээллийн санд оруулж ажиллалаа. Ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдах 23 иргэнд бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг Нийгмийн Даатгалын Хэлтэст гаргаж өгсөн

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд:

2. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтын хүрээнд Зуунмод, Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 307 сурагч, МСҮТөвийн 58 сурагч нийт 365 сурагчид мэргэжил сонголтын талаар сургалт зохион байгуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд:**Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн хүрээнд:**

ХХҮГазрын төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн 2020.08.03-ны өдрийн хуралдаанаар АБДХөтөлбөрт дэмжигдсэн Дэлгэрхаан, Зуунмод сумын 3 иргэний 15,0 сая, ХБИАБДХөтөлбөрт дэмжигдсэн Зуунмод сумын 1 иргэний 3,0 сая, АМЗҮХХөтөлбөрт дэмжигдсэн 1 иргэний 3,0 сая, нийт 21,0 сая ₮-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг ХЭДСангаас олгож 5 ажлын байрны бүртгэл мэдээллийг ХЗЗМСанд баталгаажуулсан.

Зохион байгуулалтай ажлын байрыг дэмжих арга хэмжээний хүрээнд:

ХХҮГазрын даргатай байгуулсан гэрээний дагуу сумын Засаг даргын захирамжаар баталгаажигдсан ажлуудыг гүйцэтгэсэн Борнуур сумын “Бид чадна” бүлгийн 7,8,9,10 дугаар сарын цалин нийт 2,0 сая ₮-ийн санхүүжилт олголоо.

Ахмад мэргэжилний зөвлөх үйлчилгээний хүрээнд:

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ авахыг хүссэн Зуунмод сумын Ланс 2-р багийн Засаг дарга, Эрдэнэсант сумын ЗДТГазрын МЭҮТасгийн дарга болон ХХҮГазрын даргатай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээг амжилттай хэрэгжүүлж тайлангаа ирүүлсэн Зуунмод сумын ахмад А.Баасанбаяр, Эрдэнэсант сумын ахмад Ш.Дулмаа нарын гэрээний хэрэгжилтийг дүгнэж нийт 1,7 сая ₮-ийн санхүүжилтийг ХЭДСангаас олгосон.

Гэрээт малчныг дэмжих арга хэмжээний хүрээнд:

Дээрх арга хэмжээнд 2019 онд хамрагдан сумын Засаг дарга болон ХХҮГазрын даргатай байгуулсан гэрээний дагуу үүргээ амжилттай биелүүлж гэрээт малчдын цалинг тогтмол олгож, НДШимтгэлийг бүрэн төлсөн Заамар сумын малчин ажил олгогч М.Содбаярын НДШимтгэл, гэрээт малчин М.Мөнхсайханы НДШимтгэл, ЭМДШимтгэлийг гэрээнд заасан хэмжээгээр төлж, ХЭДСангаас нийт 252,0 мянган ₮-ийн нөхөн олговрыг малчин ажил олгогчид санхүүгийн баримтыг үндэслэн нөхөн олгосон. Засгийн газар, салбарын яамнаас шинэчлэн гаргасан хууль эрх зүйн баримт бичгийн талаар сумын мэргэжилтэн болон малчдад зөвлөмж өгч ажиллав.

Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт шалгалтын хүрээнд:

ХХҮГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Батсүмбэр, Борнуур суманд 3 хоногийн хугацаатай ажиллаж, нийт 10 ААН-ийн 8 шинэ ажлын байр, 23 зуучлал бүртгэн ХЗЗМСанд баталгаажуулсан. ХЭДХөтөлбөрүүдэд 2018-2020 онд хамрагдсан дээрх сумдын 11 өрхийг түүвэрчилж, үйл ажиллагаатай танилцсан ба 3 иргэний 460.0 мянган ₮-ийн эргэн төлөлтийг хийлгэж, 13 иргэнд 4,6 сая ₮-ийн мэдэгдэх хуудас өгч, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөлөө.

Эрүүл мэндийн салбар:

1. Аймгийн хэмжээнд 2020 оны 10 сарын байдлаар 896 эх төрж өнгөрсөн мөн үеийнхээс төрөлт 64-өөр буурсан ба 899 нярай бүртгэгдсэн байна. Нийт 286781 иргэнд үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 131618, амбулаторийн үзлэг 111902, идэвхтэй хяналтын 21281 үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 15348 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, стационарт 11436 хүн эмчлэгдэн нийт 84501 ор хоног ашигласан. Дундаж ор хоног 7,4 байна.
2. 27 сумын хэмжээнд 0-5 насны 9500 гаруй хүүхэд буюу зорилтот насны хүүхдийн 80,1% нь А аминдэм витаминжуулалтад хамрагдсан.
3. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд 4 удаа тодотгол хийж, коронавирусийн цар тахлын үед дайчлагдах хүний нөөц, эм эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалх хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын судалгаа гаргаж, нөөц бүрдүүлэн ажиллаж байна.
4. ЭМЯ-аас нийлүүлсэн 3000 ширхэг Ковид-19 вирусийн антиген илрүүлэх хурдавчилсан тестийг Нэгдсэн эмнэлэг, өрх, 26 сумын Эрүүл мэндийн төвүүдэд хуваарилаж, оношлуураар хангалаа.
5. Коронавирусийн халдварын 7 сэжигтэй тохиолдлын голомтод ажиллан хариу арга хэмжээг гүйцэтгэн ажилласан.

6. ХӨСҮТ-д PCR шинжилгээнд 55 иргэний анхан болон давтан 69 сорьцыг хүргүүлсэн. Шинжилгээний хариу хүлээгдэж байгаа 2 сорьц байна.
7. 26 сум, өрхийн Эрүүл мэндийн төвд шинжилгээ авах цэг байгуулан, 1305 иргэнд Ковид-19 вирусийн түргэвчилсэн тестээр шинжилгээ хийлээ. Үүний 1160 иргэний мэдээлэл Burtgel.mohs.mn сайтад бүргэгдэн орсон байна.
8. Коронавирусийн халдварын сэжигтэй болон дам хавьтал, орон нутагт шилжилт хийн ирсэн 177 иргэнийг гэрийн хяналтад авч харьяа эрүүл мэндийн байгууллагуудад мэдээллийг дамжуулан хяналт тавин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 101 иргэн байна.
9. Төв аймгийн Батсүмбэр, Баян, Сэргэлэн, Архуст сумын нутаг дэвсгэрт харьяалагдах төмөр замын өртөөний албан хаагчдыг короновирусийн шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг зохион байгууллаа.
10. Коронавирусийн голомтын урьдчилан сэргийлэх болон эцсийн халдваргүйжүүлэлтийг 2078 мкв талбайд хийж гүйцэтгэсэн.
11. Халдварт өвчний 26 тохиолдлын голомтод тархвар зүйн тандалт судалгаа хийж голомтын болон эцсийн халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэлээ. Үүнд Энтеровирус 13, Салхинцэцэг 8, бусад тууралтат халдвар 4, цусан суулга 2, гахайн хавдар 1 тус бүр бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 1 гахайн хавдар тархвар судлалын заалтаар үгүйсгэгдсэн.
12. Тендерийн 4-р улирлын эм, эмнэлгийн хэрэгслийг 26 сумын Эрүүл мэндийн төвд түгээж, хангалт хийлээ.
13. ЭМГ-ын даргын баталсан удирдамжаар Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн командлалын эмнэлгийн тусламж үйлчилгээнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөн туслав. Ажлын байр үнэлэх аргачлалаар үнэлгээ хийхэд нийт 76 оноо буюу 93.8% “Шаардлага хангасан” үнэлгээ авсан.
14. Өвөлжилтийн бэлэн байдлын мэдээ:
 - Аймаг дотроо 290
 - Өөр сум, аймагт-60
 - Өөр сум, аймгаас оторлож байгаа малчин – 40 байгаагаас
 - Жирэмсэн -5
 - 0-5 насны хүүхэд – 93
 - Өндөр настан – 29
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн – 76
 - Архаг суурь өвчтэй хүн – 20 байна.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө 10 сарын байдлаар орон нутаг 4698.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 6511.3 сая төгрөг төвлөрүүлж 138,6 хувьтай, 1812.9 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давуулан биелсэн байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 13572.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 15940.4 сая төгрөг төвлөрүүлж 117.4 хувьтай, 2368,1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 4379.0 сая төгрөгөөр давж, 119.7 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Аргалант, Батсүмбэр, Баянжаргалан, Баянхангай, Баянцагаан, Баянцогт, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр, Угтаал, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант, Зуунмод зэрэг 18 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Архуст, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянчандмань, Заамар зэрэг 6 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баян, Жаргалант, Сэргэлэн зэрэг нийт 3 сум байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Сумдад эхний 10 сарын байдлаар нийт 66439,5 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл:

Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 33023,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 22294.6 сая төгрөг
 -Хүүхдийн цэцэрлэгт 10729.3 сая төгрөг тус тус олгоод байна.
 Эрүүл мэндийн сайдын багцаас 7572,3 сая төгрөгийг олгосон. Үүнд:
 -Сумдын эрүүл мэндийн төвд 7195,8 сая төгрөг
 -Өрхийн эмнэлэгт 376,5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 591,6 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 457.4 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 24794,3 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Үүнээс:

-Сумдын ИТХ, ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 14667.7 мянган төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 10126,6 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар:

2020 оны 10-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 198841,6 мянган төгрөгийн авлага, 239180.7 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 53121,1 мянган төгрөг буюу 22.2 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг 27367,0 мянган төгрөг буюу 11.4 хувь нь цалингийн өглөг, 12605.0 мянган төгрөг буюу 5.3 хувь нь НДШимтгэлийн өр, 1419.8 мянган төгрөг буюу 0.6 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 61705.8 мянган төгрөг буюу 25.8 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 82962,0 мянган төгрөг буюу 34,7 хувийг бусад өр эзэлж байна

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

2020 оны жилийн эцсийн тайлан мэдээг сумд, агентлаг, байгууллагуудаас 2020 оны 12 дугаар сарын 20-ны дотор эцэслэж нэгтгэж авахаар бэлтгэл ажлаа хангаад байна. Үүнд:

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэл Засаг даргын захирамжийн хэрэгжилт

Аймгийн Засаг дарга салбарын сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт

Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан

Сумын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн тайлан

Төв аймгийн Засаг дарга болон сумдын Засаг дарга нарын хооронд, Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний тайлан

“Хөгжлийн түүчээ-Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хамт аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хоёрдугаар хуралдааны 01 дүгээр тогтоолоор батлуулаад байна.

Төв аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг 49 зорилт 262 үйл ажиллагаатай, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 50 зорилт 243 үйл ажиллагаатай тус тус боловсруулан батлуулахаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гуравдугаар хуралдаанд өргөн бариад байна.

Санхүүгийн хяналт-шинжилгээний биелэлтийн талаар:

2020 оны 11 дугаар сарын 30-ны байдлаар Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийсэн. Үүнд:

Сумдаар:

Сум хөгжүүлэх сан,

Эргэлтийн эмийн сан,

Орон нутгийн хөгжлийн сан,

Баянчандмань сумын политехникийн коллеж,

Эрдэнэ сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв,

Зуунмод сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв,

Сүмбэр, Жаргалант сумын төсөвт байгууллагууд,

Баянжаргалан, Баяндэлгэр, Баян, Сэргэлэн Угтаалцайдам, Цээл, Баянцогт, Аргалант, Дэлгэрхаан, Лүн,

Баянхангай, Заамар сумын төсөвт байгууллагууд,

Батсүмбэр сумын эрүүл мэндийн төв,

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль,
 Баян-Өнжүүл сумын эрүүл мэндийн төв,
 Зуунмод сумын 4 дүгээр сургууль,
 Зуунмод 5 дугаар сургууль,
 Аймгийн төвд:

Музей,

Боловсрол соёл урлагийн газар,

Монгол туургатан театр,

Хүнс хөдөө аж ахуйн газар,

Мал эмнэлгийн газар,

Стандарт хэмжил зүйн хэлтэс,

Гэр бүл, хүүхэд залуучуудын газар

Биеийн тамир, спортын газар

Ус цаг уур, орчны шинжилгээний газар

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар

Насан туршийн боловсролын төвийн 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж нийт 1940135,2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс 243751,0 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт, 1696384,1 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага тогтоов. Улсын байцаагчийн актаас 121715,1 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Өмнөх оны актын үлдэгдэл 106775,2 мянган төгрөгөөс 30955.0 мянган төгрөг төлөгдсөн байна. Өмнөх оны актын төлөгдөөгүй үлдэгдлийн судалгааг гаргаж Төв аймгийн прокурорын газарт шилжүүлсэн болно.

Нийт актын биелэлт 43,6 хувьтай байна.

Найм. Цэргийн штабын хүрээнд:

1. 2020 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр аймгийн Засаг даргын захирамжаар Цэргийн штабын дарга дэд хурандаа Т.Төмөрчөдөөр ахлуулсан ажлын хэсэг томилогдон Төрийн тахилагат “Богд хан цэцээ гүн” хайрханы тэнгэрийг тайх ёслолын үйл ажиллагааг Нийслэлийн ЗДТГ-тай хамтран зохион байгууллаа.
2. Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын А/572 дугаар захирамжаар томилогдсон “корона вирус халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээ зохион байгуулах салбар хоорондын баг”-уудын бүрэлдэхүүнд Цэргийн штаб төлөвлөлтийн багт үүрэг гүйцэтгэн, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэн ажиллаж байна. Цэргийн штабын дарга, офицерууд нь Шуурхай штабын хариуцлагатай жижүүрээр тус бүр 2 удаа үүрэг гүйцэтгэж сумын шуурхай штаб болон аж ахуй нэгж иргэдээс ирсэн мэдээ мэдээлэл, өргөдөл, санал хүсэлт, албан тоотыг цаг алдалгүй хүлээн авч аймгийн Онцгой комисст танилцуулж асуудлыг тухай бүр шийдвэрлүүллээ..
3. Дайчилгааны төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлтэй цэргийн дайчилгааны тодотголыг 11 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд хийж тайлан мэдээг ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газарт хүргүүлэн ажилласан.
4. Аймгийн ИТХ-ын II, III Хуралдаанаар Хөгжлийн түүчээ-Төв аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төв аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд ЗДТГ-ын Цэргийн штабтай холбоотой зүйл заалтуудыг оруулж батлууллаа.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар